


ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР



**ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН
АЖЛЫН АЛБА**

2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ. /НХТЖҮЧ-ийн 9. НЗДҮАХ-ийн 6.1.1-р арга хэмжээ/

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-ын дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулахыг Барилга хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарт даалгасан. Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч хамтран “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар”-ыг боловсруулан Засгийн газрын 13 яам, Нийслэлийн 42 байгууллагуудаас санал авч, батлуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/860, А/1201 дугаар захирамжийн дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай байгуулан ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Эхлэлийн тайланг Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020 оны 141, А/1015 дугаар хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын орлогч, төслүүдийн удирдагч нар болон нийслэлийн бусад удирдлагуудад 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлын явц, төлөвлөлтийн үзэл баримтлалыг танилцуулан санал, зөвлөмж авч тусгасан.
- Хот байгуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулахад шаардлагатай хөрөнгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2021 онд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулах хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын албан бичгээр хүргүүлсэн бөгөөд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулахад Барилга, хот байгуулалтын сайдын 2021 онд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтад 300 сая, 2022 онд 338.3 сая төгрөг тусгагдсан.
- Хот байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зураг төслийн мэргэжлийн байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны академи, их дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачдын санал, зөвлөмж, шинэ санаачилгыг сонсох, олон нийтийн оролцоог хангах зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдрийн хооронд эхний хэлэлцүүлгийг 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 10-ны өдрийн хооронд 2 дахь удаагийн цахим хэлэлцүүлгийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулж 1200 гаруй хүнийг хамруулсан бөгөөд 548 асуулт асууж, 229 санал, зөвлөмжийг хэлэлцсэн.
- Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 01/279 дугаартай албан бичгээр ирүүлсэн Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дундын тайлангийн гүйцэтгэлийг хянаж 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Газар барилгажилтын мэргэжлийн зөвлөл /комисс/-ийн 16 дугаар хурлаар хэлэлцүүлж хүлээн авсан.



- Монгол Улсын засгийн газрын 14 яамнаас Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулах салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа ажил, төсөл хөтөлбөр, бодлого шийдвэр, холбогдох мэдээ, мэдээллийг тоон хэлбэрээр /*.dwg, *.shp, *.xls, *.ppt, *.pdf, *.docx/ ирүүлэх тухай Нийслэлийн Засаг даргын албан бичгийг 2021 оны 06 дугаар сарын 14-ны өдөр, ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн шийдэлд тусгуулах саналаа ирүүлэх тухай албан бичгийг 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр т хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/715 дугаар захирамжийн дагуу хэрэгжүүлэгч агентлагууд, Нийслэлийн өмчит харьяа байгууллагууд, Инженерийн дэд бүтцийн хангагч байгууллагуудын нийт 45 албан хаагчид 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 24-ны өдрийн хооронд ажиллаж нийт 487 хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсөл арга хэмжээг 2021-2040 он хүртэл 5, 5 жилээр 4 үе шаттай хэрэгжүүлэхээр боловсруулж, хэрэгжих хугацаа, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүлээгдэж буй үр дүн, нийт хөрөнгийн хэмжээг тодорхойлсон саналыг боловсруулж авсан.
- Нийслэлийн 9 дүүрэг, 172 хороонд Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг танилцуулж санал авах хэлэлцүүлэг, сургалтын хөтөлбөрийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд дүүргийн удирдлагууд, хороодын Засаг дарга, хэсгийн ахлахууд, хот байгуулалтын салбар хариуцсан албан хаагчдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг танилцуулж тэдний санал, шүүмжийг авсан.



- Монгол Улсын Засгийн газрын 14 яам, тэдгээрийн харьяа газрын удирдлага, салбарын бодлого төлөвлөлт хариуцсан албан хаагчдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг танилцуулж санал авах хэлэлцүүлгийн хөтөлбөрийг Нийслэлийн Засаг даргаар батлуулан, хөтөлбөрийн дагуу 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 22-ны өдрүүдэд санал, шүүмжийг авсан.
- Монголын Архитекторуудын Эвлэлийн дэргэдэх Хот төлөвлөлт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн хурал болон Монголын Архитекторуудын Эвлэлийн гишүүд, архитекторуудад танилцуулах хэлэлцүүлгийг 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж тэдний санал, зөвлөмжийг авсан.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн албан хаагчдад 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр танилцуулж санал авсан.
- “Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам”-ын дагуу Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хоорондох сарын хугацаанд иргэд, олон нийтээс <https://ulaanbaatar2040.mn/> вэб хуудас, Улаанбаатар 2040 Facebook, twitter, Instagram, YouTube зэрэг олон нийтийн цахим сүлжээний хэрэгслүүд болон харьяа хороогоор дамжуулан санал авах үйл ажиллагааг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулсан. Санал асуулгад нийт 32,230 иргэн оролцож санал ирүүлснээс 12,907 иргэн цахимаар, 19,323 иргэн цаасаар өгсөн бол иргэдийн 91% нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг дэмжсэн санал ирүүлсэн.





- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн албан хаагчдад 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр танилцуулж санал авсан.
- 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн.



- 2021 оны 11 дүгээр сарын 08-ний өдөр НИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн.
- 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Мэргэжлийн зөвлөл /комисс/-ийн 21 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн эцсийн тайланг хүлээн авсан.
- 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр НИТХ-ын Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлсэн.
- 2021 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр НИТХ дахь Ардчилсан намын бүлэг, Монгол Ардын намын бүлгийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж санал, зөвлөмж авсан.
- 2021 оны 11 дүгээр сарын 12-ний өдөр НИТХ дахь Ардчилсан намын бүлгийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж санал, зөвлөмж авсан.

2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус IV хуралдаанаар хэлэлцүүлж “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг дэмжих тухай” 2021 оны IV-04/30 дугаар тогтоол гарсан



- 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайдын 239 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичигт экспертиз хийх орон тооны бус экспертүүд томилогдон ажиллаж Магадлалын нэгдсэн дүгнэлт хийгдсэн.
- 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Шадар сайдын ажлын албаны дарга, газрын дарга, албан хаагчдад танилцуулж санал, зөвлөмж авсан.




- 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх тухай Нийслэлийн Засаг даргын албан бичгийг Барилга, хот байгуулалтын сайдад хүргүүлсэн.
- Монгол Улсын Засгийн газрын яамд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, Нийслэлийн 9 дүүрэг, хувийн аж ахуй нэгж байгууллагуудаас Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т тухай бүр хүргүүлж ажилласан.
- Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020 оны 141, А/1015 дугаар хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн 2021 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн хуралдаанаар эцсийн тайланг хэлэлцүүлж хүлээн авсан.
- 2021 оны 11 дүгээр сарын 10-ы өдөр Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн.
- “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төслийн саналыг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 02/4000 дугаар албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.

“Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлыг Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, санал өгч ажиллана. /ЗГҮАХ-ийн 3.7.4, НЗДҮАХ-ийн 6.2.1.1-р арга хэмжээ/

Нийслэл хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар хийгдэж байгаа “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-тэй уялдуулах зорилгоор “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц”-ын судалгаа, тайлан, мэдээллийг /тоон хэлбэрээр/ Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”

боловсруулж байгаа судалгааны багтай 2021 оны 03 дугаар сарын 05, 2021 оны 03 дугаар сарын 12, 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрүүдэд нийт 3 удаагийн уулзалтыг зохион байгуулж Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хүн амын хэтийн тооцооллын талаар санал хэлэлцсэн бөгөөд Улсын хэмжээний нийт хүн амын хэдэн хувь нь Нийслэл Улаанбаатар хотод оршин суурьших шийдлийн талаар хүн ам зүйн төлөвлөлтийн зөвлөхүүд хамтран нарийвчлан хэлэлцэж хүн амын тооцоог эцэслэхээр шийдвэрлэсэн. Уулзалтаас гаргасан шийдвэрийн дагуу Улаанбаатар хотын хэмжээнд хийгдсэн хүн ам, нийгэм, эдийн засгийн төлөвлөлтийн таамаглалыг Барилгын хөгжлийн төвд хүргүүлж тус газраас Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн 2040 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй уул уурхай, зам тээвэр, үйлдвэр, эрчим хүчний мега төслүүдийн хүрээнд шууд болон шууд бусаар нэмэгдэж болох ажлын байр, түүнийг даган нэмэгдэх хүн амын тоо зэрэг хэтийн тооцоололтой холбоотой мэдээллийг авч ажлын уялдааг хангуулан ажиллаж байна.



Мөн Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Үндэсний хөгжлийн газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 171, А-65, А/625 дугаар хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангах ажлын хэсгийн хурал 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан. Тус хуралд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Хүн амын нутагшил суурьшлын ерөнхий төсөл, Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын гүйцэтгэлийг тус тус танилцуулж ажлын хэсгийн гишүүдээс гарсан санал зөвлөмжийг бодлогын баримт бичигт тусгуулах ажлыг хамтран зохион байгуулан ажиллаж байна.

["Бүсийн хөгжлийн хөтөлбөр" боловсруулах ажлыг Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, санал өгч ажиллана. /ЗГҮАХ-ийн 3.7.4, НЗДҮАХ-ийн 6.2.1.1-р арга хэмжээ/](#)

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-тэй уялдуулах үүднээс тус ажлын явцын тайлан, холбогдох мэдээллийг ирүүлэх хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/2266 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Үндэсний хөгжлийн газрын даргын хамтарсан 171, А-65, А625 дугаар тушаал, захирамжаар 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын хэмжээнд хийгдэж байгаа Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал,

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг хот байгуулалтын баримт бичгүүдийг боловсруулах ажлуудын хоорондын уялдааг хангах, нэгдсэн удирдлагаар зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг 2021 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр хуралдаж гурван бодлогын баримт бичгийн уялдааг хангуулах талаар хэлэлцсэн.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний эцсийн тайланд санал авах тухай Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01/4746 дугаартай албан бичгийг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.

[Агаар орчны бохирдлыг бууруулах гэр хорооллын “Хөгжлийн үүд төсөл”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төслийг батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллана. /НЗДҮАХ-ийн 6.1.1.2-р арга хэмжээ/](#)

Агаар орчны бохирдлыг бууруулах, гэр хорооллын “Хөгжлийн үүд” төслийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж Залуус 1, 2, 3 орон сууцны хорооллын байршил, хариуцах байгууллага, төсөл хэрэгжүүлэх байршлуудын газрын асуудлыг тодорхойлсны үндсэн дээр зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Хурлаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 17-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж тус асуудлыг дахин Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 133 дугаар тогтоолоор батлуулсан.

[“Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн ТЭЗҮ, ХЕТ боловсруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, зураг төслийн ажилд захиалагчийн хяналт тавин ажиллана. /НЗДҮАХ-ийн 6.1.1.2-р арга хэмжээ/](#)

“Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг төслийн эх үүсвэр Нийслэлийн 2021 оны төсөвт тус зураг төслийг боловсруулах хөрөнгийн эх үүсвэр тусгагдаагүй тул нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгуулахаар зураг төслийн үнийн задаргааг боловсруулж Захиргаа санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

[Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 4 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавин ажиллана. /НЗДҮАХ-ийн 6.1.1.3-р арга хэмжээ/](#)

Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх “Зуслангийн 4 ам”-ны ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах зургийн даалгаарыг 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 2020/03 дугаартай Нийслэлийн Засаг даргаар батлуулан Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүлээлгэн өгсөн. Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/126 дугаар “Эрх шилжүүлэх тухай” захирамжаар Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх “Зуслангийн 4 ам”-ны ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын худалдан авах ажиллагаа, захиалагчийн хяналт тавин ажиллахыг Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд шилжүүлсэн.


2020 оны 06 дугаар сард үнэлгээний хороо байгуулагдан, гүйцэтгэгчээр “Ланд овнер” ХХК шалгаран гэрээ боловсруулагдан, Нийслэлийн Засаг даргын тамгын газар батлуулахаар өгсөн боловч ковид-19-ийн халдвартай холбоотойгоор төсөв татагдсан. 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 02/1585 дугаар хамтран ажиллаж, мэдээлэл ирүүлэх тухай албан бичгийг Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлж нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд зуслангийн 4 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах төсвийг тусгуулсан.

[Хүн ам, барилгажилтын нягтралыг хориглох судалгаа, төлөвлөлтийн шийдлийг боловсруулж шийдвэр гаргуулж хэрэгжилтийг хангуулан ажиллана. /НЗДҮАХ-ийн 6.1.1.4-р арга хэмжээ/](#)

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/1148 дугаар “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зарим арга хэмжээний тухай” захирамжаар гарсан 111 байршил, 1044 га талбайд гарсан нягтрал хэтэрсэн талбайг дахин судалж, талбайг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн газар нутгийг 1181 блок болгон хуваасныг шинэчлэн Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн 24,778 га газар нутгийг 1198 блок болгон хувааж өөрчилсөн, хуваалт тус бүр одоогийн барилгажилтын нягтралын тооцоог

хийж гаргаж хуваалт тус бүр өрхийн тоог гарган хүн амын нягтралыг тооцоолж гарган судалгаа хийснийг танилцуулга болгон боловсруулан ажилласан.

Нийслэл Улаанбаатар хотын Эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх үндэс суурийг бүрдүүлэх, Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулахтай уялдуулан иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар (Богдхан уулын дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар) нутаг болон схем зурагт үзүүлсэн байршилд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн үйлчилгээний барилга, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, зам, замын байгууламж, тохижилт, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбай барихаас бусад зориулалтаар шинээр газар эзэмших, ашиглах эрх олгох, барилга байгууламж барих зөвшөөрөл олгох, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдах хүртэл хугацаанд түр зогсоох тухай Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/653 дугаар захирамжийг гаргуулсан.



[Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавин ажиллана. /НЗДҮАХ-ийн 6.1.1.5-р арга хэмжээ/](#)

Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах хөрөнгийн эх үүсвэр нийслэлийн 2021 оны төсөвт тусгагдаагүй тул Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд

тусгуулахаар 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 02/394 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Нисэх, яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, зураг төслийн ажилд захиалагчийн хяналт тавин ажиллана. /НЗДҮАХ-ийн 6.1.2.1-р арга хэмжээ/

Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах зохион байгуулах чиглэлээр зураг төсөл боловсруулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх төсвийн төслийн саналыг боловсруулж Барилга, хот байгуулалтын сайдад 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлсэн. Нийслэлийн Засаг Даргын 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/427 дугаар захирамжаар Нисэх, Яармаг орчмын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлыг Хот байгуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/427 дугаар захирамжаар Нисэх, Яармаг орчмын ерөнхий төлөвлөгөөний тодотголын зураг төсөл боловсруулах ажлыг Хот байгуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Захирамжийн дагуу 2021/02 дугаар ажлын даалгаврыг эцэслэн боловсруулж Нийслэлийн Засаг даргаар 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдөр батлуулан нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/651 дүгээр захирамжаар Улаанбаатар хотын төлөвлөлтийн “27 дугаар нэгж хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хувийн хэвшил, иргэдийн оролцоотой боловсруулахаар шийдвэрлэсэн. Захирамжийн дагуу 2021/14 дугаар зургийн даалгаврыг боловсруулан Нийслэлийн Засаг даргаар 2021 оны 09 дугаар сарын 02-ний өдөр батлуулан зураг төслийн “Сонголт дизайн” ХХК 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж 2022 оны 04 дүгээр сарын 15-ны хооронд гүйцэтгэхээр зөвлөх үйлчилгээний 2021/А/651/01 дугаар гэрээ байгуулан захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, хот байгуулалтын чиглэлээр хийгдэж буй төсөл хөтөлбөрүүдийн уялдааг хангах зорилгоор Хан-Уул дүүргийн 4, 8, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн нийт 989 га талбайд боловсруулж буй хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний “Эхлэлийн шатны тайлан”-г зөвлөх үйлчилгээний гэрээнд тогтсон хугацаанд батлагдсан ажлын даалгаварт нийцүүлэн гэрээний биелэлтийг хангуулан ирүүлэх тухай 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 02/4025 дугаар албан мэдэгдэл хүргүүлсэн.

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгч биелэлтийг хангуулан ажиллана. /НЗДҮАХ-ийн 6.1.9-р арга хэмжээ/

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлэх арга хэмжээ, барилга байгууламжийн байршлыг “Нийслэлийн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-ний нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгуулах санал, зурган мэдээллийг нэгтгэж Нийслэлийн Газар Зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд Хот байгуулалтын суурь судалгаа, “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-ийн үзэл баримтлалыг хүргүүлж хамтран ажиллаж 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 02/3128 дугаартай албан бичгээр Нийслэлийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах саналын бэлтгэж Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.


ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД

НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛААР СУДАЛГАА ХИЙХ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ЧАНАР, ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛОХ

Хүй долоо худаг дахь “монгол наадам цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулж монгол улсын засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/201 дугаар захирамжийн дагуу Хүй долоо худаг дахь “Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг боловсруулж 2018 оны 1703/2018 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлт гаргасан бөгөөд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 25 дугаар хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 78 дугаар тогтоол, Монголын архитекторуудын эвлэл Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 3 дугаар хурлаар тус тус хэлэлцүүлж дэмжигдсэн.

Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх саналыг 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 02/470 тоот албан бичгээр дахин хүргүүлж 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 02/470 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлснээр 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Тус хурлаас гаргасан шийдвэрийн дагуу “Монгол наадам цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол” боловсруулах ажлыг хэлэлцүүлсэн бөгөөд



Богдхан төмөр замын чиглэл /трасс/-тэй нарийн уялдуулсны үндсэн дээр тус асуудлыг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу Богдхан төмөр замын чиглэл /трасс/-ийн Хүй долоо худаг дахь Монгол наадам цогцолбор орчмоор дайран өнгөрч байгаа хэсгийг хэрхэн төлөвлөсөн болон трассын сүүлийн эцэслэсэн хувилбарыг ирүүлэх тухай 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 02/1895 дугаартай албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 08/3014 дугаартай албан бичгээр ирүүлсэн Богдхан төмөр замын чиглэл /трасс/-ийн сүүлийн эцэслэсэн хувилбарыг Хүй долоо худаг дахь “Монгол наадам цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголд тусган ажиллах чиглэлийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т хүргүүлсэн. Тус хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр холбогдох танилцуулга, тараах хэвлэмэл материалыг бэлтгэн Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.

“Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хорооны 210 га нутаг дэвсгэрт орон сууцны VII хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулна.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/619, А/768 дугаар захирамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12-р хорооны нутаг дэвсгэрт 210 га талбайд “Орон сууцны VII нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол” боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Эн Эй Пи групп” ХХК шалгарч НХААГ-19/152 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан ажилд захиалагчийн хяналт тавин ажилласан.

Тус ажлын эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн 05 дугаар хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүний хөгжлийн хорооны 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хурал, Нийслэлийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо, Байгаль орчин ногоон байгууламжийн байнгын хорооны 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 08/22 дугаар тогтоолоор эцэслэн батлуулах ажлыг зохион байгуулан ажилласан.



[Багахангай дүүргийн "хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк"-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулна](#)

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/528 дугаар захирамжийн дагуу Багахангай дүүргийн “Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр “Аесн” ХХК шалгарч 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн №НХААГ-20/0111 дугаартай зөвлөх гэрээ байгуулсан.

Тус ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавин ажилласан бөгөөд Ковид-19 цар тахалтай холбоотой ажлын гүйцэтгэлийг хянаж мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хугацаа хойшилсон тул зөвлөх үйлчилгээний гэрээний хугацааг 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэл №НХААГ-20/0111-01/01 дугаартай сунгалтын гэрээ байгуулсан.


Багахангай дүүргийн “Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл”-ийн эцсийн тайланг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн /комисс/-ийн 07 дугаар хурлаар хэлэлцүүлж хурлаас гарсан санал зөвлөмжийг тусгуулан эцэслэн хүлээн авсан. Багахангай дүүргийн “Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл”-ийг Монголын Архитекторуудын Эвлэлийн дэргэдэх Хот төлөвлөлт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан. Тус ажлын эцсийн тайланд улсын экспертээр хянуулж магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах ажлыг “Аесн” ХХК хариуцан ажиллаж байна.



Хотын дэд төвийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд санал өгөх, зураг төсөл боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавин ажиллана. /Улаанбаатар хотын доторх төвлөрлийг задлах зорилгоор нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх/

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/625 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотын төлөвлөлтийн Баруун-1 бүсийн 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Урбан девелопмент консалтинг групп” ХХК шалгарсан. Тус ажлын үе шатны тайлангуудад захиалагчийн хяналт тавин ажилласан бөгөөд эцсийн тайланг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн /комисс/-ийн 07 дугаар хуралд танилцуулж зөвлөлийн гишүүдийн асуултад хариулж нэмэлт мэдээлэл өгч ажилласан.

Улаанбаатар хотын төлөвлөлтийн Баруун-1 бүсийн 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эцсийн тайланг Монголын Архитекторуудын Эвлэлийн дэргэдэх Хот төлөвлөлт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан. Тус ажлын эцсийн тайланд улсын экспертээр хянуулж магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах ажлыг “Урбан девелопмент консалтинг групп ХХК хариуцан ажиллаж байна. Нийслэлийн Засаг Даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн А/524 дугаар захирамжийн дагуу “Амгалан дэд төв”, “Шинэ төв”, “Сонсголон дэд төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ, “Дарь-Эх олон нийтийн төв”, Монел олон нийтийн төв” Тахилт олон нийтийн төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Зураг төсөл консалтинг” ХХК, “Бичил олон нийтийн төв”, “Ургах наран олон нийтийн төв”, Хайлааст олон нийтийн төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Арткон” ХХК тус тус шалгарсан. Тус олон нийтийн төв, дэд төвийн төлөвлөлтийн эхлэлийн тайланг хянан үзэж 2021 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 25 дугаар хурлаар хэлэлцүүлсэн.



Улаанбаатар хотын төлөвлөлтийн баруун өмнөд бүсийн 27-р нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд захиалагчийн хяналт тавин ажиллах.


Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/651 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотын төлөвлөлтийн 27 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг боловсруулж 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг даргаар батлуулан гүйцэтгэгч байгууллагад хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/651 дүгээр захирамжаар Улаанбаатар хотын төлөвлөлтийн “27 дугаар нэгж хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотой гүйцэтгүүлэхээр зөвлөх үйлчилгээний 2021/А/651/01 дугаар гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 15-ны хооронд “Сонголт дизайн” ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан.

[Зарим Их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх судалгаа, шийдэл боловсруулж холбогдох хурлаар хэлэлцүүлнэ.](#)

Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх судалгаа, төлөвлөлтийн шийдлийг тусгаж 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдрийн хооронд иргэд олон нийт, эрдэмтэн судлаачдын дунд шат дараалсан цахим хэлэлцүүлгүүдийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулсан.

Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн их дээд сургууль, коллежийн судалгаа хийгдсэн бөгөөд төлөвлөлтийн урьдчилсан шийдлийг Боловсрол, шинжлэх ухааны яам, Барилга хот байгуулалтын яам болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтарсан ажлын хэсэг байгуулж Засгийн газарт танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх судалгаа болон төлөвлөлтийн шийдлийг тусгаж ажиллах тухай санал зөвлөмжийг 2021 оны 09 дүгээр сарын 20-24-ний өдрийн хооронд Нийслэлийн Засаг Даргын А/715 захирамжаар байгуулагдсан мэргэжлийн чиглэлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-д хүргүүлсэн.



[“Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд санал, зөвлөмж өгч хамтран ажиллана.](#)

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 55 дугаар тогтоолоор Шинэ зуун мод (Аэро сити), Майдар шинэ хотыг байгуулах шийдвэр гарсан. Барилга, хот байгуулалтын яамнаас захиалагчийн хяналт тавин ажиллаж байгаа Шинэ зуун мод (Аэро сити) хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, “Майдар хот” төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах ажлын тайлантай танилцан санал хүргүүлэх тухай 2021 оны 02 дугаар сарын 08-ний өдрийн 02/308 дугаартай албан бичгийг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 390 дугаар тогтоолын дагуу Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар хийгдсэн “Майдар хот төсөл”-ийн Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ болон түүнд зориулсан инженер-геологийн судалгааны тайлан, газрын төлөв байдал чанарын хянан баталгааны тайлан болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар хийгдсэн “Майдар хот төсөл” хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газар доорх усны хайгуул, судалгаатай холбоотой мэдээллийг Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгч “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.

Газрын брэндбүүк боловсруулж батлуулна.


Хот байгуулалт, хөгжлийн газрын харагдах байдлаараа хэрэглэгчдэд хэрхэн хүрэхийг тодорхойлж харуулсан удирдамж бүхий боловсруулагдсан бичиг баримт болох Брэндбүүкийг боловсруулан ажиллаж байгууллагын лого дизайн болох логотой хамт бичигдэх нэр, үг хэллэг, хэрэглэгдэх хаяг, өнгөний хослол хэрэглэгддэг элементүүдийн загварыг боловсруулж, нэгдсэн нэг загварын дагуу нэгжүүдийн хэрэглэгдэх загвар, график дизайны шийдлүүдийг боловсруулан ажилласан.





Улаанбаатар хотын барилга байгууламжийн өнгөний нэгдсэн судалгаа, шийдлийг боловсруулж холбогдох хүрлээр хэлэлцүүлнэ.

Улаанбаатар хотын барилгын өнгөний нэгдсэн шийдлийг гаргах судалгааг хийж Улаанбаатар хотын барилгуудын одоо байгаа зонхилох өнгийг тодорхойлон, цаашид дагаж мөрдөх өнгөний зохицлыг гаргах судалгааг боловсруулж Албаны дарга болон албан хаагчдад танилцуулан ирүүлсэн санал, зөвлөмжүүдийг тусган шинэчлэн сайжруулан боловсруулсан саналыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т хүргүүлэн Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг, зураглалд тусгуулсан.



Улаанбаатар хотын түүхэн барилга, байгууламжийн хадгалалт хамгаалалтын судалгаа, шийдлийг боловсруулж холбогдох хурлаар хэлэлцүүлнэ.

Улаанбаатар хотын түүхэн барилга байгууламж хадгалалт, хамгаалалт судалгааны ажлын хүрээнд соёлын өвийн тухай хууль, барилгын тухай хууль, хот байгуулалтын тухай хууль, соёлын өвийг хамгаалах сэргээн засварлалтын ажлын дүрэм журам, Монгол Улсын Засгийн Газрын соёлын өвийн зэрэглэл тогтоож хамгаалалтад авсан захирамж, Нийслэлийн Засаг даргын захирамж, олон улсын соёлын өвийг хамгаалалтад авах, зэрэглэл тогтоох журам, Барилга хот байгуулалтын яамны захиалгаар Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-ын хийсэн түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах төслийг судлан танилцуулга бэлтгэж Ерөнхий архитекторын ажлын албаны хурлаар танилцуулсан.

Тус ажлын хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журмын төсөлд санал өгсөн. Улаанбаатар хотын хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний эцсийн тайлангийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын ботийг судлан санал боловсруулсан.



ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД ОРОЛЦОХ, САНАЛ ӨГЧ АЖИЛЛАХ.

- Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд тусгуулах саналыг шинэчлэн бэлтгэж 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.
- Нийслэлийн 2021 оны төсөвт шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээнд зориулж батлагдсан 3 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тусгуулах саналыг нэгтгэж Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
- Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор төлөвлөлтөөр багтаамж ихтэй ямар тээврийн хэрэгслийг ямар маршрутын дагуу төлөвлөж байгаа болон төлөвлөлтийн нэгж хорооллын хуваалтыг оновчтой болгох талаар 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Хот төлөвлөлт, судалгааны институтийн ерөнхий инженер, төлөвлөлт судалгааны хэлтсийн дарга нартай уулзалт хийж төлөвлөлтийн шийдлийн саналыг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т албан бичгээр хүргүүлсэн.
- Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний төсөлд тусгуулах, зорилт арга хэмжээний саналыг боловсруулан Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлсэн.
- Улаанбаатар хотын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах төлөвлөгөөний саналыг боловсруулж тоон хэлбэрээр /Arcgis программ/ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.
- Монгол улсын Засгийн газраас тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээнд тусгуулах Нэг төвт хотоос олон төвт хот болгох зорилтын хүрээнд Улаанбаатар

хотод шинээр 3 дэд төв, 7 олон нийтийн төв байгуулах ажлын судалгаа, хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоо, хэрэгжүүлэх ажлын үе шатны танилцуулга болон төслийн үндсэн мэдээллийн хүснэгтийг загварын дагуу боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтэс хүргүүлсэн. Мөн 3 дэд төв, 7 олон нийтийн төв байгуулах асуудлыг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлтөд тусгуулах саналыг хүргүүлсэн.

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/ -ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд “Эдийн засгийн чөлөөт бүс” байгуулах байршил, төлөвлөлтийн шийдлийг тусгасан бөгөөд Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний шийдэлд тусгаж ажиллах саналыг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02/137 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд ажлын нарийвчилсан зураг төсөл, Техник эдийн засгийн үндэслэл боловсруулахаар тусгагдсан бөгөөд хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр хүлээгдэж байна.
- Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд төрийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн жагсаалтыг Хот байгуулалт, хөгжлийн газрын хэмжээнд нэгтгэж 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 02/1070 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
- Монгол улсын Засгийн газраас тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээнд тусгуулах Нийслэлд хэрэгжиж буй, шинээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн Дэд төвүүдийг байгуулах, LR□ багтаамж ихтэй тээврийн хэрэгслийн судалгаа, товч танилцуулга, хөрөнгө оруулалтын тооцоог хийж 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтэст хүргүүлсэн.
- Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу Улаанбаатар хотын дагуул, хаяа, хот, тосгодын төлөвлөлтийн уялдааг хангуулж, дагуул хотуудад логистик төв, эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн парк байгуулах, тэдгээрийг холбосон нийтийн тээврийн сүлжээ байгуулах ажлын талаар санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/542 дугаартай захирамжийг гаргуулсан.
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/542 дугаартай захирамжаар байгуулагдсан Улаанбаатар хотын дагуул хот, тосгодын төлөвлөлтийн уялдааг хангуулж, дагуул хотуудад логистик төв, эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн парк байгуулах, тэдгээрийг холбосон нийтийн тээврийн сүлжээ байгуулах ажлын талаар санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн ээлжит хурлыг 2021 оны 08 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулсан. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу ажлын хэсгийн гишүүдийн өгсөн санал, зөвлөмжийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн ээлжит хуралд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулахаар бэлтгэл ажлыг ханган ажилласан.
- “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлэх арга хэмжээ, барилга байгууламжийн байршлыг “Нийслэлийн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-ний нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгуулах санал, зурган мэдээллийг нэгтгэж Нийслэлийн Газар Зохион байгуулалтын албанд 2021 оны 06 дугаар сарын 18-нд хүргүүлсэн.
- КОЙКА-аас 2023 онд Монгол Улсад шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт тусгуулах саналыг боловсруулж 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 02/2074 дугаартай бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
- Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн зураг төслийн саналыг боловсруулж 2021 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 02/2165 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
- Монголын Хөл бөмбөгийн холбооноос 2021 оны 07 дугаар сарын 06-ны 02/292 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт орчин үеийн шинэ технологи буюу ЭЙРДОМ хэмээх мембрам бүрхүүлтэй хийлдэг хийцлэл бүхий хөл бөмбөгийн зориулалттай барилга, байгууламж барих хүсэлтийн дагуу хот төлөвлөлтийн баримт бичиг тусгагдсан боломжит байршлуудын судалгааг гарган нийслэлийн Спортын хороонд 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 02/2134 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

- 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 02/2034, 02/2036 дугаартай албан бичгээр Нийслэлийн Газар Зохион байгуулалтын алба, Нийслэлийн Хот Байгуулалт Хөгжлийн газар, Хот Төлөвлөлт, Судалгааны Институт ОНӨААТҮГ-ын дарга нарын хамтарсан А/25-А/53-А/37 тушаалаар байгуулагдсан “Газарзүйн мэдээлэл солилцох талаар хамтран ажиллах тухай” ажлын хэсгийн дагуу Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд шаардлагатай мэдээллийг ажлын хэсгийн дагуу бэлтгэж батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний мэдээлэл, хамааралтай төсөл хөтөлбөрийг тоон хэлбэрээр болон зураглалын альбом болгон бэлтгэж НГЗБА-ны Өгөгдлийн сан хариуцсан мэргэжилтэн Т.Ганчимэгт хүлээлгэн өгсөн.
- “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн оролцон ажиллаж “Бүс, орон нутгийн хөгжил” болон “Улаанбаатар ба дагуул хот” дэд бүлгүүдийн зорилго, зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг боловсруулсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж баталсан.
- Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд тусгах санал хэлэлцэх хурал 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр цахимаар зохион байгуулагдсан. Тус хуралд оролцож Хот байгуулалт, хөгжлийн газрын 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажил, хөрөнгө оруулалтын талаар дэлгэрэнгүй тайлбар мэдээлэл өгч ажилласан. Тус хэлэлцүүлгийн үед орхигдсон 3 дэд төв, 7 олон нийтийн төвүүдийн ТЭЗҮ, ХЕТ барилгажилтын төсөл боловсруулах ажлын тайлбар, үндэслэл, хөрөнгө оруулалтын тооцооны задаргааг боловсруулж НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын бодлого хариуцсан мэргэжилтэн Ч.Эрдэмбилэгт 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр ERP цахим хэлбэрээр файлыг хүргүүлсэн.
- Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд тусгуулах саналыг шинэчлэн бэлтгэж Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд гүйцэтгэж буй ажлын тайлан, 2022 онд шаардагдах хөрөнгө оруулалтын жагсаалт ажлын гүйцэтгэлийн талаарх тайланг нэгтгэж 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН ЭРХ, ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

- Нийслэлийн ерөнхий архитекторын 2020 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлтсүүдээс авч нэгтгэн боловсруулж 2020 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 02/37 дугаар бүхий албан бичгээр “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм”-ийн 2.1 дэх заалтын дагуу Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу тайлан, хавсралт материалын хамт бүрдүүлж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хот төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн О.Чинбаярт 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр chinba@ar.o@gazar.gov.mn цахим хаягаар явуулсан. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Нийслэлийн ерөнхий архитекторын тайлантай танилцаж, өгсөн зөвлөмжийн дагуу тайланд нэмэлт мэдээлэл нэмж эцсийн байдлаар chinba@ar.o@gazar.gov.mn цахим хаягаар дахин хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/89 дугаар захирамжаар Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Мэргэжлийн зөвлөл /комисс/-ийн ээлжит 25 удаагийн хурлаар **1333** асуудлыг хэлэлцүүлснээс **1113** асуудал дэмжигдсэн байна.
 - 01 дүгээр сарын 26-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 01 дүгээр хурлаар 52 асуудал хэлэлцсэнээс 28 асуудал дэмжигдсэн.
 - 02 дугаар сарын 23-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 02 дугаар хурлаар 42 асуудал хэлэлцсэнээс 41 асуудал дэмжигдсэн.
 - 03 дугаар сарын 15-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 03 дугаар хурлаар 62 асуудал хэлэлцсэнээс 51 асуудал дэмжигдсэн.
 - 03 дугаар сарын 19-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 04 дүгээр хурлаар 51 асуудал хэлэлцсэнээс 37 асуудал дэмжигдсэн.
 - 04 дүгээр сарын 09-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 05 дугаар хурлаар 128 асуудал хэлэлцсэнээс 127 асуудал дэмжигдсэн.

- 04 дүгээр сарын 14-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 06 дугаар хурлаар 84 асуудал хэлэлцсэнээс 62 асуудал дэмжигдсэн.
- 04 дүгээр сарын 27-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 07 дугаар хурлаар 90 асуудал хэлэлцсэнээс 80 асуудал дэмжигдсэн.
- 04 дүгээр сарын 27-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 08 дугаар хурлаар 8 асуудал хэлэлцсэнээс 8 асуудал дэмжигдсэн.
- 06 дугаар сарын 3, 4-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 09 дүгээр хурлаар 128 асуудал хэлэлцсэнээс 106 асуудал дэмжигдсэн.
- 06 дугаар сарын 18-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 10 дугаар хурлаар 61 асуудал хэлэлцсэнээс 59 асуудал дэмжигдсэн.
- 06 дугаар сарын 25-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 11 дүгээр хурлаар 69 асуудал хэлэлцсэнээс 52 асуудал дэмжигдсэн.
- 06 дугаар сарын 29-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 12 дугаар хурлаар 2 асуудал хэлэлцсэнээс 2 асуудал дэмжигдсэн.
- 07 дугаар сарын 09-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 13 дугаар хурлаар 74 асуудал хэлэлцсэнээс 68 асуудал дэмжигдсэн.
- 07 дугаар сарын 30-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 14 дүгээр хурлаар 41 асуудал хэлэлцсэнээс 31 асуудал дэмжигдсэн.
- 07 дугаар сарын 30-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 15 дугаар хурлаар 2 асуудал хэлэлцсэнээс 2 асуудал дэмжигдсэн.
- 08 дугаар сарын 17-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 16 дугаар хурлаар 28 асуудал хэлэлцсэнээс 24 асуудал дэмжигдсэн.
- 08 дугаар сарын 23-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 17 дугаар хурлаар 60 асуудал хэлэлцсэнээс 28 асуудал дэмжигдсэн.
- 09 дүгээр сарын 8-ны өдөр Мэргэжлийн зөвлөлийн 18 дугаар хурлаар 37 асуудал хэлэлцсэнээс 15 асуудал дэмжигдсэн.
- 09 дүгээр сарын 21-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 19 дүгээр хурлаар 84 асуудал хэлэлцсэнээс 70 асуудал дэмжигдсэн.
- 10 дугаар сарын 19-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 20 дугаар хурлаар 62 асуудал хэлэлцсэнээс 55 асуудал дэмжигдсэн.
- 11 дүгээр сарын 09-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 22 дугаар хурлаар 54 асуудал хэлэлцсэнээс 52 асуудал дэмжигдсэн.
- 11 дүгээр сарын 09-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 21 дүгээр хурлаар 1 асуудал хэлэлцсэнээс 1 асуудал дэмжигдсэн.
- 11 дүгээр сарын 10-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 23 дугаар хурлаар 34 асуудал хэлэлцсэнээс 33 асуудал дэмжигдсэн.
- 11 дүгээр сарын 18-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 24 дүгээр хурлаар 38 асуудал хэлэлцсэнээс 35 асуудал дэмжигдсэн.
- 12 дугаар сарын 07-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 25 дугаар хурлаар 41 асуудал хэлэлцсэнээс 38 асуудал дэмжигдсэн.

Хурлын №	Улирал	Барилга барих хүсэлт		Дуудлага худалдаа	Хот байгуулалтын баримт бичиг	Эх загвар зураг хүчинтэй эсэх	Инженер, дэд бүтцийн төлөвлөлт	Ашиглалтын шаардлага хангахгүй,	Гэр хорооллын дахин төлөвлөлт	Авто замын төлөвлөлт	Явган хүний гарц /Гүүр/	Тохижилт	Хэлэлцүүлсэн	Дэмжигдсэн
		ХТХ	ХДХХ											
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ /КОМИСС/-ИЙН ХУРАЛ														
1.	I	28/19	21/9	-	-	1/1	-	-	2/2	-	-	-	52	28

2.	I	5/5	3/3	27/26	-	-	4/4	-	-	1/1	-	-	42	41
3.	I	24/14	9/9	8/8	-	-	5/5	3/2	5/5	5/5	2/2	4/4	62	51
4.	I	22/11	11/8	-	1/1	1/1	-	-	-	14/14	1/1	2/2	51	37
5.		9/9	2/2	-	-	2/2	5/5	2/2	1/1	26/26	-	81/80	128	127
6.		61/43	16/13	-	-	2/2	-	-	-	1/1	1/1	5/4	84	62
7.	II	23/23	7/7	-	2/2	2/1	10/10	-	1/0	2/2	1/1	35/35	90	80
8.	II	-	1/1	-	-	-	-	-	-	-	-	7/7	8	8
9.	II	51/34	29/25	-	-	4/3	21/21	4/4	-	7/7	1/1	15/15	128	106
10.	II	38/37	16/15	4/4	-	1/1	7/7	4/4	4/3	4/4	-	31/30	61	59
11.	II	54/42	9/4	-	1/1	-	5/5	-	-	-	-	8/8	69	52
12.	II		2/2						1/1				2	2
13.	III	28/23	44/43	-	-	-	2/2	30/30	-	1/1	-	6/5	74	68
14.	III	38/39	29/20	-	-	-	1/1	-	1/1	1/0	-	-	41	31
15.	III	2/2	-	-	-	-	-	-	-	-	-	-	2	2
16.	III	13/13	14/10	-	1/1					3/3		8/8	28	24
17.	III	52/21	8/7	-	-	-	-	-	-	-	-	-	60	28
18.	III	38/23	-	-	-	-	-	-	-	-	-	-	37	23
19.	IV	41/32	43/38	-	-	-	-	-	-	-	-	-	84	70
20.	IV	32/26	18/18	-	-	-	11/11	-	-	3/3	-	14/13	62	55
21.	IV	-	-	-	1/1	-	-	-	-	-	-	-	1	1
22.	IV	10/10	43/41	-	-	-	1/1	2/1	2/2	8/8	-	31/30	54	52
23.	IV	34/33		34/33									34	33
24.	IV	5/5	33/30	-	-	-	-	3/2	2/0	16/16		12/12	38	35
25.	IV	8/8	23/23	-	10/7	-	-	-	-	11/11	-	12/12	41	38
НИЙТ		857/692	388/337	73/71	16/13	14/12	60/60	63/63	21/15	103/102	6/6	271/265	1333	1113

Дэмжигдсэн асуудлуудын материалын бүрдлийг хянан, АТД, барилгажих талбайн схем зураг болон эх загвар зургийг тамгалан баталгаажуулан батлагдсан баримт бичгүүдийг бүртгэл хөтлөн ажилласан. Нийт 887 архитектур төлөвлөлтийн даалгавар, 53 ажлын зургийн даалгавар, 488 загвар зураг тамгалан баталгаажуулж бүртгэл хийн холбогдох хэлтэст хүлээлгэн өгч ажилласан.

Мэргэжлийн зөвлөл /комисс/-ийн хурлаар хэлэлцүүлсэн асуудлуудын жагсаалт болон дүгнэлтийг www.uda.ub.gov.mn байгууллагын цахим хуудсанд байршуулан, мөн холбогдох материалуудыг Z:\1.ERUNKHII ARKHI□EK□ORIIN AJLIIN ALBA4.DO□OOD AJILГБМЗХ) байршуулан байгууллагын удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан.

ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРТ МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРАМ, НОРМ, СТАНДАРТАД САНАЛ ӨГӨХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ МӨН ШИНЭ НОРМ СТАНДАРТЫН САНАЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал боловсруулж Хууль эрх зүйн хэлтэст 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн.
- Барилгын хөгжлийн төвөөс дараах норм, дүрэм, стандартын төсөлд санал боловсруулж, албан бичгээр хариу хүргүүлээд байна. Үүнд:
 - “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний газрын орон зайн төлөвлөлт”
 - Олон нийтийн барилга, байгууламж”.
 - Зочид буудлын барилга;
 - Авто зогсоол БНБД 21-02-10;
 - Газрын тос боловсруулах, нефть химийн үйлдвэрийн барилга байгууламжийн галын аюулгүйн шаардлагын норм, дүрэм;
 - Төсөв бүрдлийн норм дүрмийн 2020-2025 онд шинэчлэх үндсэн чиглэлийн төсөл;
 - Барилга байгууламжийн геодезийн ажил БНБд 11-108-21/ төсөл;
 - “Барилга байгууламжийн аюулгүйн байдлын техникийн зохицуулалт” баримт бичгийн төсөл;
 - “Төв (магистрал) дамжуулах хоолойн зураг төсөл төлөвлөлт” /БНБД/ барилгын норм ба дүрмийн төсөл;
 - “Барилгын геодезийн ажил” /БНБД 11-108-06/ барилгын норм ба дүрэм;
 - “Төсөв, үнэ бүрдлийн норм дүрмийг 2020-2025 онд шинэчлэх үндсэн чиглэл”-ийн төсөл;

- “Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт” баримт бичгийн төсөл;
- “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” /БНБД 22-01-21/-ийн тайлбар барилгын дүрмийн төсөл;
- 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газраас өөрчлөлт оруулах шаардлагатай стандарт, техник зохицуулалт, норм, нормативын баримт бичигт санал хүргүүлсэн.
- “Барилга байгууламжийн цахим тооцооллын программ хангамжийг баталгаажуулж хэрэглэх журам”, “Нэгтгэсэн хууль”-ийн төсөлд тус тус санал өгч Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.
- “Инженерийн шугам сүлжээний стандарт, төлөвлөлт хийх удирдамж” бүлгийн “Инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шаардлага” /ГЭБ 0601:А/ хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийн төсөлд санал өгч Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт хүргүүлсэн.
- “Барилга байгууламжийн цахим тооцооллын программ хангамжийг баталгаажуулаж хэрэгжүүлэх журам”-ын төслийн “3.4. Магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулахад шаардлагатай иж бүрдэлд программ хангамж эзэмших эрх, программын сургалтанд хамрагдсан гэрчилгээг хавсаргах” гэсэн чиглэлээр санал боловсруулж Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.
- “Нэгтгэсэн хууль”-ийн төсөлд нэмэлт өөрчлөлтөд тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрөлд хариуцсан чиглэлийн дагуу санал боловсруулж Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.
- Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газраас 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 01-04/276 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Орон сууцны хороолол дахь ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төлөвлөлтөд тусгах арга зүй”, “Хүүхдийн тоглоомын талбай болон авто зогсоолтой уялдуулан ногоон байгууламжийн зохистой төлөвлөлт хийх” хотын стандарт, удирдамж арга зүйн баримт бичиг боловсруулах ажлын даалгаврын төсөлд өгөх санал боловсруулан Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт хүргүүлсэн.
- Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газраас 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдөр 02-04/313 дугаар албан бичгээр ирүүлсэн “Иж бүрэн гудамж”-ны удирдамж, арга зүйн баримт бичгүүдийн төсөл:
 - Иж бүрэн гудамж – Бодлого, зарчим
 - Иж бүрэн гудамж- Гудамжны ангилал
 - Иж бүрэн гудамж- Нийтийн тээвэр зорчих гудамж
 - Иж бүрэн гудамж- Автомашинаар зорчих гудамж
 - Иж бүрэн гудамж – Гудамжны уулзварт тусгах саналыг нэгтгэн Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт хүргүүлсэн.
- “Кадсүрвей” ХХК-ийн шинээр боловсруулж буй “Замын байгууламж, унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага” нормын төслийг холбогдох нэгжүүдээс санал авч боловсруулсан.Тус нормд санал өгөхдөө харьцуулан ашиглах зорилгоор ОХУ-ын норм болон FHWA bikewa Selection Guide-ний зарим зүйл заалтыг болон шаардлагатай зурган мэдээлэл, тоон мэдээллийг орчуулан саналыг боловсруулсан.
- Барилга Байгууламжийн норм, нормативын сан”-ийн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний дагуу боловсруулж буй “Барилгын материал, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн зохицуулалт” ийн баримт бичгийн төсөлд дараах саналыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ний өдөр 02/3727 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
- Барилгын Хөгжлийн төвөөс 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр "Барилга, байгууламжийн норм, нормативын сан"-ийн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний дагуу шинэчлэн боловсруулж буй “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт” БНБД 30-01-21-ийн төсөлд тусгуулах саналыг Ерөнхий архитекторын ажлын алба, Хот төлөвлөлтийн хэлтэс, Хот дахин хөгжүүлэх хэлтэс болон Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн албан хаагчид 2021 оны 11 дүгээр сарын 10-14-ний өдрүүдэд хуралдан, тусгах саналыг боловсруулж, 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 02/3723 дугаар албан бичгээр Барилгын хөгжлийн төвд болон Нийслэлийн Засаг даргын тамгын газарт нийт 93 санал хүргүүлсэн.
- Харилцаа холбооны зохицуулах хороонд мэдээлэл харилцаа холбооны салбарт нэн тэргүүнд шаардлагатай гэж үзэж буй стандарт, норматив баримт бичгийн талаарх саналыг 2021 оны 11 сарын 24-ний өдөр хавсралтаар Харилцаа холбооны зохицуулах газарт хүргүүлсэн.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООДОД ОРЖ АЖИЛЛАСАН БАЙДАЛ:

- Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/42 дугаар тушаалаар байгуулагдсан “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулсан.
- Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/16 дугаар тушаалаар байгуулагдсан “Морингийн даваа-1” төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2021 оны 03 дугаар сарын 03, 2021 оны 03 дугаар сарын 15, 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаануудад оролцсон бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.18 дугаар заалтын дагуу “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын хамтарсан түншлэлтэй шууд гэрээ байгуулж ажиллахаар шийдвэрлэсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дараах ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:
 - “Морингийн даваа” 1 төслийн Техник эдийн засгийн үндэслэл
 - “Морингийн даваа” 1 төслийн эхний ээлжийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл
 - “Морингийн даваа” 1 төслийн эхний ээлжийн ажлын зураг төсөл
 - “Морингийн даваа” 1 төслийн эхний ээлжийн авто зам, замын байгууламжийн доогуурх хонгилын систем
 - “Морингийн даваа” 1 төслийн эхний ээлжийн цахилгаан хангамж болон инженерийн бэлтгэл арга хэмжээ

ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ТҮҮНИЙ ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ, САНАЛ ДҮГНЭЛТ ГАРГАХ ХҮРЭЭНД:

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хан-Уул дүүргийн 10, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх орон сууцны “Залуус” хорооллын техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төслийг боловсруулж БХБЯ-нд 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02/364 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.
- Соёлын яамнаас ирүүлсэн Мэргэн Тоньюкукийн музей цогцолбор барилгын ажлын зураг, төсөв боловсруулах даалгаварт санал боловсруулж 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр тус яамны инженер Д.Энхээтэй холбогдож /bd.enkhee@gmail.com/ цахимаар илгээсэн
- Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороонд баригдах түүх шашны соёлыг дэлгэрүүлэх төв “Богд Зонхова” барилгын ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаварт өгөх саналыг боловсруулж 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Хот байгуулалт хөгжлийн газарт Соёлын яамны инженер Д.Энхээ-д хүргүүлж өгсөн.
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 117 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Улаанбаатар хот, Багануур дүүргийн 2, 5 дугаар хорооны барилгажилтын төсөл боловсруулах ажлын даалгаврын төслийг боловсруулж газрын даргад танилцуулсан.
- Налайх дүүргийн үйлдвэрлэл технологийн паркийн зориулалтаар 130 га талбайд шинээр боловсруулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврын төслийг боловсруулж Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Тус ажлын гүйцэтгэгчээр “Өрх ХХК” шалгарч Барилга Хот байгуулалтын яамтай 2021 оны 01 дүгээр сарын 28-нд 2021/47 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан.
- Нийслэлийн Засаг Даргын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/334 дүгээр захирамжаар “Эко орчин-цэвэр агаар” аян зохион байгуулах тухай ажлын хүрээнд тус аяны удирдамжийг боловсруулж, ажлын хэсгийн ахлагчид хүлээлгэн өгсөн болно.
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/524 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд шинээр байгуулах “Амгалан”, “Шинэ”, “Сонсголон” дэд төв болон “Монель”, “Нисэх”, “Бичил”, “Дарь-Эх”, “Ургах наран”, “Тахилт”, “Хайлааст” олон нийтийн төв хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах зургийн даалгаврыг боловсруулж Нийслэлийн Засаг даргаар батлуулсан.

- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/651 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотын төлөвлөлтийн 27 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг боловсруулж 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг даргаар батлуулан гүйцэтгэгч байгууллагад хүргүүлсэн.
- Туул голын ай сав дагуух эргийн хамгаалалтын байгууламж, тохижилт, амралт зугаалгын бүсийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаварт 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр санал ИДБТ-ийн хэлтэст өгсөн.

ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ:

- Монгол-Японы төв, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-аас зохион байгуулсан Улаанбаатар хот болон Төв аймаг дахь ногоон хот байгуулалтыг дэмжих төслийн талаар цахим хуралд 2021 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр мэргэжилтэн Б.Амарсанаа оролцсон.
- Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд олон нийтийн оролцоог хангах, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны академи, их дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачдад төлөвлөлтийн талаарх мэдээлэл өгөх, тэдний санал, зөвлөмжийг тусгах зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдрийн хооронд шат дараалсан цахим хэлэлцүүлгүүдийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулж нэгжийн бүх албан хаагчид оролцсон.
- Архитектур ба хот төлөвлөлт сэдэвт цахим хэлэлцүүлэгт Албаны дарга А.Баттөмөр модираторын үүрэг гүйцэтгэж Ахлах мэргэжилтэн Г.Хосбаяр, Г.Дарханчулуун мэргэжилтэн Б.Оюунбат нар 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдөр оролцсон.
- “УЛААНБААТАР УС-ЦЭВЭР ОРЧИН 2021” эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр цахимаар зохион байгуулагдаж байна. Тус эрдэм шинжилгээ, онол практикийн бага хуралд “Хот төлөвлөлт, архитектурын шийдэл, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ”, “Ногоон барилга” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлэгт оролцсон.
- 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Барилга, байгууламжийн зураг төсөл зохиогчийн төлөөлөлтэй уулзаж тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэн, тэдний санал, зөвлөмжийг сонсох зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын Газартай хамтарсан уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын үеэр иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллөөс Улаанбаатар хотын хот байгуулалтын бодлого, үйл ажиллагааг сайжруулахад тусгуулах саналыг авсан.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр харьяа байгууллагуудын албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, санал солилцох уулзалтад албаны нийт албан хаагчид хамрагдсан.
- Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг олон нийтэд таниулах хялбаршуулсан багц 10 номын агуулга боловсруулах, дэмжлэг үзүүлэх, зөвлөх, чиглүүлэх зорилгоор 2021 оны 11-р сарын 12, 13-ны өдрүүдэд Удирдлагын академи дээр ажилласан. Тус уулзалтад “Улаанбаатар ба дагуул хот” бүлгийн агуулга, статистик тоо мэдээлэл, зураглал хэсгийг сайжруулахад дэмжлэг үзүүлж холбогдох тоо мэдээллийг шинэчлэн боловсруулсан.
- Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газраас Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн дунд 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан “Cit Agencies Ignite talk” арга хэмжээнд оролцон Улаанбаатар ба хот төлөвлөлт сэдвээр илтгэл тавьж ажилласан.
- 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Дэлхийн өвлийн хотуудын дарга нарын холбооны 19-р хурлын хуваарь болон илтгэл бэлдэх тухай ирсэн албан бичгийн дагуу Улаанбаатар хотын байршил, цаг уур, цаг уураас улбаатай тулгамдаж буй асуудлууд, ерөнхий төлөвлөгөө болон цаашид хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний талаар англи-монгол хэл дээр танилцуулга бэлдэж, Нийслэлийн Засаг Даргын тамгын газрын гадаад харилцааны хэлтэст хүлээлгэн өгсөн. 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Дэлхийн Өвлийн хотуудын Засаг Дарга нарын 19-р хуралд Хот байгуулалт, хөгжлийн газар болон Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын Төслийн зохицуулагч Э.Болд-Эрдэнэтэй 12:00-15:00 цагийн хооронд оролцож, Улаанбаатар хотын уур амьсгалын өөрчлөлт, үүнээс үүдэлтэй хотын шилжилт хөдөлгөөний талаар танилцуулж мөн шийдвэрлэх арга хэмжээний нэг болох дэд төвийн төлөвлөлтийн талаар хэлэлцүүлэн амжилттай оролцсон.

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛЬ ТОГТООМЖ, ШИЙДВЭРИЙН ХЯНАЛТАД АВСАН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН АЖИЛЛАЖ, ТАЙЛАГНАХ:

- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2021 оны хэрэгжилтийг гаргаж Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.2.1.9-ийн дагуу гүйцэтгэж буй ажлын биелэлтийг гаргаж 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Хот байгуулалт, хөгжлийн газрын Ерөнхий архитекторын ажлын албаны чиг үүргийн дагуу хариуцсан ажлын 2021 оны хэрэгжилтийн явцын тайланг гаргаж 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Захиргаа, санхүүгийн хэлтэст өгсөн.
- Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
- Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлт
- НЗД-ийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
- НЭЗ нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт
- НИТХ, НИТХТ-ийн тогтоол, хурлын тэмдэглэл
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, үүрэг даалгавар
- Нийслэлийн удирдах ажилчдын шуурхай
- Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврын биелэлтүүдийг цаг хугацаанд нь гаргаж Захиргаа санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ХАРИУТАЙ БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд Захиргаа санхүүгийн хэлтэст Ерөнхий архитекторын ажлын албаны архивын 16 боть баримт бичгийг хүлээлгэн өгсөн.
- 2021 оны 6 сарын байдлаар хариутай, хариугүй нийт 332 албан бичиг ирүүлсэн ба 221 албан бичиг төлөвлөж явуулсан.

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2021 оны жилийн эцсийн байдлаар аж ахуй нэгж, иргэдээс нийт 13 өргөдөл гомдол ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн.

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж төрийн албан хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг нэгжийн нийт албан хаагчид хуулийн хугацаанд мэдүүлсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ

- Улаанбаатар хотын 1938-2020 оны ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотын суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн тэлэлт, түүхэн барилга байгууламжийн талаар 26 хуудас бүхий



- Хот төлөвлөлт ба аялал жуулчлал чиглэлээр 26 хуудас бүхий мэдээлэл бэлтгэн танилцуулга боловсруулж байгууллагын вэб сайтад нийтэлсэн.



- Хот төлөвлөлт ба Газар чиглэлээр 30 хуудас бүхий мэдээлэл бэлтгэн танилцуулга боловсруулж байгууллагын вэб сайтад нийтэлсэн.



- Сар шинийн баяр, Зэвсэгт хүчний 100 жилийн ой, Эх үрсийн баяр, барилгын салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн баяр, ахмадуудын баяр, Монголын Архитекторуудын Эвлэлийн 65 жилийн ойн баяр, Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 382 жилийн ойн баярын мэндчилгээний постерийг боловсруулан байгууллагын цахим хуудсанд нийтэлсэн.





Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, сурталчлан танилцуулах ажлын хүрээнд Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын 2021 оны хэвлэл, олон нийтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргаар батлуулсан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- “Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор байгуулах” концепц, загвар зураг боловсруулах уралдааны зарласан тухай ярилцлагыг 2021 оны 04 дугаар сарын 30-ний өдөр www.ulaanbaatar.mn өгсөн.



- 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих ажлын төсөл хэрэгжүүлэгчдийн батламжийг гардуулж гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдээлэл;
- 2021 оны 05 дугаар сарын 14-ны өдөр Өглөөний мэнд Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа UBS телевизийн Ажилсаг Улаанбаатар нэвтрүүлэгт Хот байгуулалт хөгжлийн газраас оролцож Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах үйл явц, “Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор” байгуулах үзэл баримтлал /концепц/, загвар зураг боловсруулах уралдаан, Богдхан уулын “Авто зогсоол - Дугуй цагаан” чиглэлийн явган аяллын замыг тохижуулах судалгааны талаар мэдээлэл өгсөн;
- 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах урилга зарлах мэдээлэл;
- 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр “Мөрөөдлийн хот” хүүхдийн гар зургийн уралдаанд ирүүлсэн бүтээлд олон нийтээс санал авч байгаа мэдээлэл;



- 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй Нэхмэлийн шарын байруудыг буулган шинээр барих төслийн хүрээнд баригдсан орон сууцны барилгуудын дунд тохижилтын ажлыг эхлүүлж байгаа мэдээлэл;

- 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Барилга, байгууламжийн зураг төсөл зохиогчийн төлөөлөлтэй уулзаж тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэн, тэдний санал, зөвлөмжийг сонсох зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтарсан уулзалтыг зохион байгуулсан уулзалтын талаарх мэдээлэл;
- 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Хот байгуулалт хөгжлийн газрын нийт албан хаагчдыг хүлээн авч уулзан тэдний санал, зөвлөмжийг сонссон талаарх мэдээлэл;
- 2021 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Богдхан ууланд мод тарих аянд нэгдэж Богдхан уулын “Авто зогсоол-Дугуй цагаан” чиглэлийн явган аяллын замыг хувийн хэвшилтэй хамтран тохижуулах ажлын хүрээнд Богдхан уулын баруун ширээт, дугуй цагаан руу алхдаг хэсэгт мод тарьсан талаарх мэдээлэл;
- 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Мөрөөдлийн хот” хүүхдийн гар зургийн уралдааны шилдгүүдийг тодруулан шагнал гардуулж байгаа талаарх мэдээлэл;
- 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр “Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор” байгуулах үзэл баримтлал /концепц/, загвар зураг боловсруулах уралдааны шилдгүүдийг тодруулан шагнал гардуулж байгаа талаарх мэдээлэл;
- 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Өглөөний мэнд Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа Ажилсаг Улаанбаатар нэвтрүүлэгт Хот байгуулалт, хөгжлийн газраас оролцож Улаанбаатар хотын голуудын хөгжлийн төлөвлөлт, Сэлбэ голын тохижилтын зураг төсөл, “Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор” байгуулах үзэл баримтлал /концепц/, загвар зураг боловсруулах уралдааны талаар мэдээлэл өгсөн.
- 2021 оны 06 дугаар сарын 04-ны өдөр □NB телевизийн Цагийн хүрд нэвтрүүлэгт оролцож Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үйл явц, цаашид хийгдэх ажлын талаар ярилцлага өгсөн.
- 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаас Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Гандан орчмыг соёлын аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх саналыг дэмжиж Техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах үүрэг чиглэлийг өгсөн тухай мэдээлэл;
- 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагааны хүрээнд амжилттай хэрэгжсэн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын төслийн талаарх мэдээлэл;
- 2021 оны 06 дугаар сарын 29-ны өдөр Нийслэлийн Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн тухай мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Барилгын зураг төсөл зохиогчдын ажлын гүйцэтгэлийн чанарыг сайжруулах мэдэгдэл;
- 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдөр шинээр гудамж, зам нэршүүлэх, хүндэтгэлийн самбарыг байршуулах мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 7-ны өдөр Хотын соёл аяны хүрээнд хийгдсэн нэвтрүүлэгт оролцон Хот төлөвлөлт ба иргэдийн оролцоо сэдвээр ярилцлага өгсөн;
- Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газраас Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн дунд 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан “Cit □ Agencies Ignite talk” арга хэмжээнд оролцон Улаанбаатар ба хот төлөвлөлт сэдвээр илтгэл, танилцуулга хийсэн;
- 2021 оны 07 дугаар сарын 7-ны өдөр Орон сууцны VII нэгж хорооллын шинэчилсэн төлөвлөлтийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан тухай мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 7-ны өдөр Нийслэлийн Засаг даргын газрын эрхийг цуцалсан Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай Нэхмэлийн шар байруудын дунд тохижилтын ажлын хүрээнд 40 авто машины зогсоол, явган хүний зам, талбайг хийж гүйцэтгэсэн талаарх мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 8-ны өдөр Барилга угсралтын ажил хийгдэж дуусалгүй удаан хугацаагаар зогссон, хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлж буй хотын төвд байрлалтай 10 барилгад Барилгын тухай хуульд заасан хамгаалалтын горимд шилжүүлэх, барилгын түр хашаа, саравчийг стандартын дагуу хийх, төсөл хэрэгжих хугацаа, төлөвлөгөөг ирүүлж орчны аюулгүй байдлыг хангуулах тухай зөвлөмж өгсөн тухай мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 8-ны өдөр Барилгын түр хашааны шаардлага хангаагүй, орчны аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй 44 барилгын захиалагч иргэн, аж ахуй нэгжид Нийслэлийн Ерөнхий архитекторын зөрчил арилгах тухай шаардах хуудас хүргүүлсэн тухай мэдээлэл;

- 2021 оны 07 дугаар сарын 17-ны өдөр “Баянхошуу” дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон дэд төв байгуулах ажлын хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалтын талаарх мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 18-ны өдөр Налайх дүүргийн Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний талаарх мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Нэхмэлийн шарын 12, 13, 17, 18 дугаар орон сууцны байруудыг буулган дахин төлөвлөн барилгажуулах төслийн хэрэгжүүлэгч “Хару констракшн” ХХК-ийн төлөөлөл, холбогдох албаны хүмүүстэй хамтарсан уулзалт хийж зэргэлдээ төсөл хэрэгжүүлж байгаа барилга, байгууламжийн төлөвлөлттэй барилга хоорондын зайг уялдуулах, батлагдсан загвар зургийн дагуу ногоон байгууламж, авто зогсоолыг хийж гүйцэтгэхийг үүрэг болгосон талаарх мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 21-ны өдөр Эмээлтийн арьс ширний үйлдвэрийн, үйлдвэрлэл технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний талаарх мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 24-ны өдөр Багахангай дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний талаарх мэдээлэл;
- 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Багануур дагуул хотын ерөнхий төлөвлөгөөний талаарх мэдээлэл;
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/653 дугаар захирамжаар иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар (Богдхан уулын дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар) нутаг болон схем зурагт үзүүлсэн байршилд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн үйлчилгээний барилга, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, зам, замын байгууламж, тохижилт, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбай барихаас бусад зориулалтаар шинээр газар эзэмших, ашиглах эрх олгох, барилга байгууламж барих зөвшөөрөл олгох, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдах хүртэл хугацаанд түр зогсоох шийдвэрийг гаргуулж олон нийтэд мэдээлсэн.
- 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр UBS телевизийн Ажилсаг Улаанбаатар нэвтрүүлэгт оролцож хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд иргэд олон нийтээс санал авах үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн.
- 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр МҮОНТ-ийн Олон нийтийн цаг шууд нэвтрүүлгээр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн шийдлүүдийн талаар мэдээлэл өгсөн.
- 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдөр хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний эцсийн тайлангийн бүрдэл, одоогийн байдлын судалгаа, дүн шинжилгээний 199 хуудас тайланг хянаж холбогдох засвар зөвлөмжийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Хот байгуулалт, нийгэм эдийн засгийн хэлтэст хүргүүлсэн.
- 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Монголын Мэдээ агентлагийн өдрийн зочны цагт оролцож хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд иргэд олон нийтээс санал авах үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн.
- 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/789 дугаар захирамжаар байгуулагдсан “Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам”-ын дагуу Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлж санал авах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг хуралдаж Олон дагагчтай олны танил хүмүүсээр дамжуулан сурталчлах, чөллэнж явуулах, Засгийн газрын мэдээ болон яамд, сайд, түүний харьяа байгууллагын сайт, пэйж хуудсаар мэдээлэх, НИТХ-ын төлөөлөгчдөөр дамжуулж иргэдэд мэдээлэх, egr.ulaanbaatar.mn систем ашигладаг албан хаагчаар санал өгүүлэн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.
- 2021 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцүүлсэн тухай мэдээлэл;
- 2021 оны 11 дүгээр сарын 08-ний өдөр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг НИТХ-р хэлэлцүүлсэн тухай мэдээлэл;

- 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг НИТХ-ын Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлсэн тухай мэдээлэл;
- 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих Төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтад урьж байгаа тухай мэдээлэл;
- 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг НИТХ-аас дэмжсэн тухай мэдээлэл;
- 2021 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр барилгын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж байгаа тухай тухай мэдээлэл;
- 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Шадар сайдын ажлын албаны дарга, газрын дарга, албан хаагчдад танилцуулж санал, зөвлөмж авсан мэдээлэл;
- 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Хот байгуулалт, хөгжлийн газраас явуулж буй Сайн үйлсийн аяны хүрээнд албан хаагчид “Цусаа хандивлах” үйл ажиллагаанд оролцсон талаарх мэдээлэл;
- 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Хот байгуулалт, хөгжлийн газрын "I-UP" мэдээллийн цонхоор Хот байгуулалтын хүртээмжийн төсөл сэдвийн хүрээнд “Налуу зам”-ыг онцлон хийсэн судалгааны ажлын талаарх мэдээлэл;

Дээрх мэдээллүүдийг Хот байгуулалт, хөгжлийн газрын вэб сайт, facebook page хуудас болон Ulaanbaatar.mn, нийслэлийн мэдээ facebook page хуудсанд байршуулан иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэл өгч ажилласан.

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөлтийн талаар иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэл өгөх:

- Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөлтийн талаар иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэл өгөх зорилгоор UBS телевизийн “Ажилласаг Улаанбаатар” өглөөний хөтөлбөрийн 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн дугаарт ярилцлага өгсөн.



- Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын түүхэн хөгжил, хотын аялал жуулчлал, хот төлөвлөлт ба газар олголт сэдвийн хүрээнд судалгаа хийж видео танилцуулга хийж олон нийтийн сүлжээнд нийтэлсэн.
- Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөлтийн талаар иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэл өгөх зорилгоор UBS телевизийн “Ажилласаг Улаанбаатар” өглөөний хөтөлбөрийн 2021 оны 06 дугаар сарын 03-ний өдрийн дугаарт ярилцлага өгсөн.
- Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны хэрэгжилт, төлөвлөлтийн талаар иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэл өгөх зорилгоор “7 телевиз”-ийн ажлын өглөө шууд нэвтрүүлэгт оролцсон.



- Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй болгох, сурталчлан таниулах ажлын хүрээнд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Жанжин Д.Сүхбаатарын талбайд 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулах ажилд оролцож “Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд санал авах ажлыг зохион байгуулан ажилласан.
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 28/15 дугаар тогтоолоор батлагдсан “Гандантэгчэнлин хийд” орчмын гэр хорооллын шинэчилсэн дахин төлөвлөлтийн төслийн ажлын явцын талаар С1 телевизэд 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ярилцлага өгсөн.

БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ АРХИВЫН БАЯЖИЛТ БҮРДҮҮЛЭЛТ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ӨГСӨН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Газрын даргын 2020 оны А/85 дугаар тушаалаар байгуулагдсан хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн өгөгдөл, мэдээллийг шалгах, нөхөн бүрдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ажлын хүрээнд Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний “dwg” тоон хэлбэрийг “shp” тоон хэлбэрт шилжүүлэн зурж архитектур орон зайн мэдээллийг “shp” тоон хэлбэрээр Хот байгуулалтын мэдээллийн сангийн ХЕТ цэсэнд оруулсан.

- Толгойт нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Баянхошуу нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Хайлааст нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Чингэлтэй нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Дамбадаржаа хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Дарь эх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Шархад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- 10-р нэгж хороол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- 14-р нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- 15-р нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- 16-р нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- 17-р нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- 18-р нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- 31-р нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Баруун-2 бүс / Үйлдвэр-1 / хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Баруун-2 бүс / Үйлдвэр-2 / хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Баруун-2 бүс / Үйлдвэр-3 / хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Хан-Уул дүүрэг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Багахангай дүүрэг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- 9-нэгж хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Гандан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Баянголын амны орон сууцны хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Налайх дүүрэг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Багануур дүүрэг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Баянголын 2,3-р нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- Орон сууцны VII нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол

СУРГАЛТ, МЭДЛЭГ ЧАДВАР

1. Төрийн албаны мэдлэг чадвараа дээшлүүлэх дотоод сургалт, семинарт хамрагдсан байдал:
 - Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах батлах, хэрэгжилтийг хангах журам”, 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ыг хэрэгжүүлэх аргачлал, загварыг танилцуулсан “Үр дүнд

- суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” 4 модуль цахим хичээлд нэгжийн албан хаагчид хамрагдан гэрчилгээ авсан,
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газраас цахимаар 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан сургалтад Ахлах мэргэжилтэн Г.Дарханчулуун оролцсон.
 - Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сургалтад 3 хоног оролцож 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр шалгалт өгч сургалтад хамрагдсан гэрчилгээ авсан.
 - Улс нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийн танилцуулга, албан бичгийн журам, Edoc, ERP, өргөдөл гомдлын системийн талаар сургалтад 2021 оны 05 дугаар сарын 13-14 өдрүүдэд цахимаар хамрагдсан.
 - Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх арга хэмжээний тухай” А/276 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг хэрэглэх, стандарт норм дүрмийн хэрэгжилтийг хангах нь” сэдэвт цахим сургалтад 2021 оны 05 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд хамрагдсан.
 - “Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт ба төрийн албаны шинэтгэл” сэдэвт сургалтад 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр хамрагдсан.
 - Төрийн албан хаагчийн Манлайлал ба гүйцэтгэлийн менежмент сэдэвт сургалтад 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр 4 албан хаагч хамрагдсан.
 - Цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сэдэвт цахим сургалтад 2021 оны 10 сарын 07-ны өдрийн 10.00-11.00 хооронд цахим хэлбэрээр хамрагдсан.
 - Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 382 жилийн ойг тохиолдуулан НЗДТГ-ын Сургалт, судалгааны төвөөс нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын дунд 10 сарын 23-нд болсон мэтгэлцээний тэмцээнд Ерөнхий архитекторын ажлын албаны ахлах мэргэжилтэн Г.Дарханчулуун, Г.Хосбаяр, мэргэжилтэн Б.Амарсанаа нар оролцсон.
 - Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Харилцааны ур чадвар” сэдэвт сургалтад 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр цахимаар хамрагдсан.
 - Төрийн албаны зөвлөлөөс Пүрэв гариг болгонд зохион байгуулдаг сургалтад хамрагдсан. /“Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 7.4.10 Арга зүйн сургалтын үр дүн” сэдэвт сургалт/
 - Үндэстний үзэл, хэл соёл, уламжлалт хэл бичгээ дээдлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулж буй Монгол бичгийн сургалтад тогтмол хамрагдаж байна.
2. Онолын болон мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдсан байдал:
- Германы хамтын ажиллагаа зохион байгуулж буй “Эрчим хүчний хэмнэлттэй барилга” цахим сургалтын 2 дугаар үе шат болох Модуль 2-ийг Г.Хэрлэн амжилттай дуусгаж, сертификат авсан.
 - ШУТИС-ийн Барилга, Архитектурын сургуульд хот төлөвлөлтийн чиглэлээр магистрын хөтөлбөрт Б.Оюунбат хамрагдаж байна.
 - МУИС-ийн “Хот ба бүс нутаг төлөвлөлт”-ийн магистрын хөтөлбөрт Ахлах мэргэжилтэн Г.Дарханчулуун хамрагдаж байна.

ДӨРӨВ. УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ, БУСАД МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 36 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийн биелэлт:

- Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 36 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу “Гандантэгчэнлин хийд орчмыг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх” ажлын явцын талаар 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдөр БХБСайд, УИХ-ын гишүүн Х.Ганхуяг нарт танилцуулга хийж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар зөвшилцсөн.



- Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 175 дугаар тушаалаар “Гандантэгчлэн хийд” орчмыг соёл, аялал жуулчлалын бүс болон хөгжүүлэхэд тулгамдсан асуудлыг судлах, тооцоо, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийн хурлыг 2021 оны 09 дүгээр сарын 03, 16-ны өдрүүдэд 2 удаа хуралдаж, газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцаж ажилласан.



“Багахангай”, “Багануур”, “Налайх” дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний танилцуулга: Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэнийн Нийслэлийн “Багахангай”, “Багануур”, “Налайх” дүүргүүдэд ажиллах ажлын хүрээнд “Багахангай”, “Багануур”, “Налайх” дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний танилцуулга болох 90*90 самбарыг боловсруулсан.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

Нийслэлийн онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийг QR кодоор бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдалд нийслэлийн агентлаг, харьяа байгууллагуудын хяналт тавьж ажиллах /НЗД-ын А/25 дугаартай захирамж/

Нийслэлийн онцгой комиссоос гаргасан хуваарийн дагуу нэгжийн албан хаагчид 01 дүгээр сарын 27-ний өдрөөс 2 дугаар сарын 07-ний өдөр хүртэл Хан-Уул дүүргийн 11, 15, 20-р хорооны нутаг дэвсгэрийн худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийг QR кодоор бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдалд нийслэлийн агентлаг, харьяа байгууллагуудын хяналт тавьж ажилласан.

“Түүхий нүүрсний тээвэрлэлт, хэрэглээнд хяналт тавих тухай” / НЗД-ын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/1156 дугаар захирамж/

Хот байгуулалт, хөгжлийн газрын Захиргааны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 25 дугаар хурлаас гарсан шийдвэрийн дагуу Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны айл өрхүүдэд “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт, түгээлт, борлуулалтын цэгийн үйл ажиллагаанд хяналт тавих, хамтран ажиллаж борлуулалтын тайлан мэдээг долоо хоног бүр тогтмол мэдээ авч нэгтгэн захиргаа санхүүгийн хэлтэст хүргүүлэн ажилласан.

Нийслэлийн Онцгой комиссоос тогтоосон хатуу хөл хорионы дэглэмийн үед “Нэг хаалга- Нэг шинжилгээ”-г зохион байгуулахад нутгийн захиргааны байгууллагуудаас дэмжлэг үзүүлэх.

Нийслэлийн онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан “Нэг хаалга- Нэг шинжилгээ”-г зохион байгуулах ажлын дагуу Нийслэлийн засаг даргын тамгын газрын 02 дугаар сарын 09-ний өдрийн 03/661 дугаартай захирамжийн дагуу Хан-Уул дүүргийн 19, 20-р хорооны нутаг дэвсгэрт 02 дугаар сарын 18-23-ны хооронд 08:00-22:00 цагийн хооронд Албаны дарга А.Баттөмөр, Ахлах мэргэжилтэн Г.Хосбаяр, Г.Дарханчулуун, мэргэжилтэн Х.Мөнх-Энэрэл, С.Вандандорж, Б.Амарсанаа, Б.Анхтөр нар хяналт тавьж зохицуулагчаар ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хан-Уул дүүргийн 10, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх орон сууцны “Залуус” хорооллын техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төслийг боловсруулж БХБЯ-нд 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02/364 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн тус ажлын хүрээнд хуучны 1-р хороолол, 3, 4-р хорооллын хүн ам, барилгажилт, нийгмийн дэд бүтцийн судалгааг боловсруулан газрын даргат танилцуулсан.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлд Нийслэлийн Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2020 оны ажлын тайланг хүргүүлэх.

Нийслэлийн Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын хууль, тогтоомжийн хүрээнд хүлээсэн эрх үүргийн дагуу 2020 онд хийж хэрэгжүүлсэн, шинээр санаачлан боловсруулсан ажлууд болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудын талаарх хураангуй танилцуулга газрын даргад танилцуулан Захиргаа санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

Түгжрэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг /Нийслэлийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/393 дугаар захирамж/

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/393 дугаар захирамжаар “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах” үүрэг бүхий ажлын хэсэгт нарийн бичгийн үүргийг гүйцэтгэж, хариуцсан ажлын хүрээнд дараах судалгаа, мэдээлэл, тооцоолол, танилцуулгыг бэлтгэж ажилласан: Үүнд

- Улаанбаатар хотын хүн ам, барилгажилтын нягтралын судалгаа,
- Улаанбаатар хотын дэд төвийн төлөвлөлтийн хэрэгжилт, цаашид хийгдэх ажлыг тодорхойлох байршлын зураглал, хөрөнгө оруулалтын тооцоо,
- Улаанбаатар хотын дэд төвийн төлөвлөлтийг хэрэгжүүлснээр гарах үр дүнд анализ,
- Улаанбаатар хотын дэд төвийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулахад шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо,

- Улаанбаатар хотын дэд төвийн бүтээн байгуулалтын урьдчилсан хөрөнгө оруулалтын тооцоо
- Улаанбаатар хотын төвлөрлийг зохицуулах нэгдсэн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын тооцоог 2021-2025 онд хийх хуваарилах, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох ажлыг нэгтгэсэн,
- Улаанбаатар хотын төвлөрлийг зохицуулах нэгдсэн хөтөлбөрийн товч танилцуулгыг нэгтгэсэн.

Ажлын хэсгээс Монгол Улсын Ерөнхий сайдын ахалж буй “Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, автозамын түгжрэлийг бууруулах” үндэсний хорооны 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоо судалгааны материалыг бэлтгэж ажилласан.

[“Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор” байгуулах үзэл баримтлал /концепц/, загвар зураг боловсруулах уралдаан /Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/338 дугаар захирамж/](#)

- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/338 дугаар захирамжийн дагуу Иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа ая тухтай, зөв боловсон өнгөрөөх орчин нөхцөлийг бий болгох зорилгоор “Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор” байгуулах үзэл баримтлал /концепц/, загвар зураг боловсруулах уралдааныг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зарласан бөгөөд уралдаанд зураг төслийн мэргэжлийн байгууллага, хувь уран бүтээлчид, оюутан, залуусын хамтарсан нийт 8 баг бүтээлээ ирүүлсэн. Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг 2021 оны 05 дугаар сарын 23-ны өдрийг дуустал Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын албан ёсны цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтээс санал авсан. Нийслэлийн Засаг даргын захирамжаар
- байгуулагдсан уралдааныг дүгнэх комисс уралдааны удирдамжид заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу уралдааныг дүгнэж нэгдсэн үнэлгээг гаргасан. Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийт 20 сая төгрөгийн шагналын санг баталсан бөгөөд шилдгийн шилдэг санаа буюу тэргүүн байр – 77.6 оноогоор “Riverside Paradise” 6-р баг 15 сая төгрөг, дэд байр – 67.45 оноогоор “Оюут” ХХК 1-р баг шалгарч таван сая төгрөгөөр тус тус шагнагдсан. Шагналыг Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ж.Сандагсүрэн, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Ц.Тулга нар шалгарсан багуудад гардуулсан.



[“Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор” байгуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг /Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/608 дугаар захирамж/](#)

Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч “Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор” барилгын үйл явцтай танилцах зорилгоор тус ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байгаа байгууллага болон гүйцэтгэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн уулзалтын зохион байгуулсан. Тус уулзалтаас өгсөн үүрэг даалгаврын дагуу “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/608 дугаартай захирамжийг гаргуулсан. Тус захирамжийн дагуу 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр, 2021 оны

09 дүгээр сарын 06-ны өдөр, 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр тус тус ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан.

- Монгол Улсын Засгийн газрын “Нийслэлийн нутгийн удирдлагын байгууллагуудыг шилжүүлэн байршуулах тухай” 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 282 дугаар тогтоолын хэрэгжүүлэх ажлын хүрээнд нутгийн захиргааны цогцолборын хэрэгжилт, санхүүжилттэй холбоотой тулгамдсан асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж “Нийслэлийн нутгийн захиргааны төв” цогцолбор барилгын талаар авах зарим арга хэмжээний тухай 118 дугаар тогтоолыг гаргуулсан.
- 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр “А блок” барилгын ажлын гүйцэтгэлд зураглал боловсруулан, орон зайг зохион байгуулах эхний ээлжийн саналыг гарсан.
- Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороонд байрлах “Нутгийн захиргааны цогцолбор” орчмын 200-300м радиус дотор шинээр байгуулан ашиглаж болох авто зам, зогсоолын хүрэлцээний судалгааг хийж танилцуулга бэлдэн газрын даргад танилцуулсан.
- 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр “Нийслэлийн нутгийн захиргааны төв” цогцолбор дээр тулгамдаад буй асуудлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, түүний харьяа агентлагуудын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, болон Ашиглалтын өмнөх захиргаатай хамтарсан хуралдаан хийсэн.
- Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх танилцуулга бэлтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 02/2933 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
- 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Нутгийн Захиргааны төв байр дээр тулгамдаад буй асуудлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, түүний харьяа агентлагуудын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, болон Ашиглалтын өмнөх захиргаа хамтран хуралдсан.

[Улаанбаатар хотын дагуул, хаяа, хот, тосгодын төлөвлөлтийн уялдааг хангуулж, дагуул хотуудад логистик төв, эдийн засгийн чөлөөт бүс, ҮТГ байгуулах тэдгээрийг холбосон нийтийн тээврийн сүлжээ байгуулах/ НЗД-ын 2021 оны А/542 дугаар захирамж/](#)

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/542 дугаартай захирамжаар байгуулагдсан Улаанбаатар хотын дагуул хот, тосгодын төлөвлөлтийн уялдааг хангуулж, дагуул хотуудад логистик төв, эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн парк байгуулах, тэдгээрийг холбосон нийтийн тээврийн сүлжээ байгуулах ажлын талаар санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн ээлжит хурлыг 2021 оны 08 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулсан. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу ажлын хэсгийн гишүүдийн өгсөн санал, зөвлөмжийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн ээлжит хуралд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулсан.

Монгол Улсын хэмжээнд хийгдэж байгаа Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг хот байгуулалтын баримт бичгүүдийг боловсруулах ажлуудын хоорондын уялдааг хангах, нэгдсэн удирдлагаар зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Үндэсний хөгжлийн газрын даргын хамтарсан 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 171, А-65, А625 дугаар тушаал, захирамжийн шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/524 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд шинээр байгуулах “Хайлааст”, “Тахилт”, “Бичил” олон нийтийн төв хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах зургийн даалгаврыг боловсруулж Нийслэлийн Засаг даргаар батлуулан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.

[“Нэг төвт хотоос олон төвт хот болгох” / НЗД-ын 2020 оны А/1262 дугаар захирамж/](#)

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1262 дугаартай захирамжаар байгуулагдсан Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний “Нэг төвт хотоос олон төвт хот болгох” зорилтын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй дэд төв, олон нийтийн төвүүдийг бий болгох ажлыг эрчимжүүлэх, удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ээлжит хурлыг 2021 оны 09 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу ажлын хэсгийн гишүүдийн өгсөн санал, зөвлөмжийг нэгтгэн шийдвэр гаргуулсан.

/НЗД-ын 2021 оны А/507 дугаар захирамж/

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/507 дугаар захирамжийг үндэслэн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай “Зайсангийн гүүрний зүүн талд” 5.0 га, “Бага тэнгэрийн ам” 3.68 га, Баянзүрх дүүргийн “Шинэ гүүрний баруун талд” 10.5 га, Баянзүрх дүүргийн “Шинэ гүүрний зүүн зүүн талд” 4.3 га, “Хан хилс” 25.4 га, Богдхан уулын “Авто зогсоол-Дугуй цагаан” чиглэлийн явган аяллын зам талбайн тохижилт 35.0 га талбайд нийт 6 байршилд ажлын зураг төсөл гүйцэтгэхээр 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажилласан. Тохижилт хийх байршлуудад одоогийн байдлын судалгаа болох байр зүйн зураглал, инженер геологийн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, тухайн байршлын онцлог давуу тал дээр тулгуурлан төлөвлөлтийн шийдлийг боловсруулан Нийслэлийн холбогдох 10 байгууллагын 14 албан тушаалтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр тохижилтын ажлын загвар зургийг 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдөр батлуулсан. Ажлын зураг боловсруулах явцад талбайн судалгааг дахин хийх шаардлага үүссэн, мөн техникийн нөхцөлүүд гараагүйн улмаас тус ажлуудын гэрээний хугацааг сунгах нэмэлт гэрээг 2021 оны 09 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл байгуулсан. Тохижилтын ажлын зураг, төсвийг гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд буюу 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр 01/320 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Гадна шугам сүлжээний зураг төсөл боловсруулахад шаардлагатай техникийн нөхцөлүүдийг 2021 оны 10 дугаар сарын 06, 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авч холбогдох байгууллагуудтай 2021 оны 11 дүгээр сарын 22 өдрийг хүртэл тодорүүлга авч зөвшилцсөн. Барилгын хөгжлийн төвтэй 2021 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн Ё-1925/2021 тоот гэрээг байгуулж, магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР.

- “Хот байгуулалтын зарим үйл ажиллагааг түр хориглох тухай” НИТХ-ын тогтоолын төслийг НИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан танилцуулга материал, хурлын тэмдэглэл, шийдвэрийн төслийг боловсруулан бэлтгэж НИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн удирдлагуудад танилцуулж санал, зөвлөмж авсан.
- Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй хэрхэн уялдуулах талаар 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлаар өгсөн үүрэг даалгаврын хүрээнд 2013-2020 оны хооронд хийгдсэн судалгаа, төсөл хөтөлбөр, ТЭЗҮ, бодлогын баримт бичгүүд болон байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, холбогдох шийдвэрийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг нэгтгэн боловсруулсан.
- Нийслэлийн засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн шуурхай хуралдаанаар Богдхан төмөр замын нөлөөлөлд өртсөн иргэдийн газрын байршлыг шилжүүлэх асуудлыг судалж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барих үүрэг даалгавар өгсөн. Тус үүрэг даалгаврын дагуу Богдхан төмөр замын шинээр төлөвлөж буй чиглэл /трасс/ хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан давхцалын талаар танилцуулга бэлтгэн ажилласан.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ҮҮРЭГ ДААЛГАВАР*Цагийн хязгаартай ажиллах авто машингүй гудамж, зам талбайн судалгаа гарган төсөл, хөтөлбөр боловсруулах /Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/292 дугаар захирамж/*

Бага тойруу орчимд 11 байршилд цагийн хязгаартай ажиллах гудамж, замын судалгаа боловсруулж, байршил тус бүрийн талбайн хэмжээ, онцлог үйл ажиллагааны чиглэлийг тусган, санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/292 дугаар захирамжаар байгуулагдсан Цагийн хязгаартай ажиллах авто машингүй гудамж, зам талбайн судалгаа гарган төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.


Чингэлтэй дүүргийн Өглөөний гудамжны концепц, судалгааг хийх.

Чингэлтэй дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Гутлын 22 гудамжийг автомашингүй “Өглөөний гудамж” болгох талаар танилцуулгыг боловсруулж 3 сарын 3-ны өдөр Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч дарга Ж.Сандагсүрэн-д танилцуулсан.



Автобусны буудлын хүртээмжийн судалгаа.

Улаанбаатар хот дотор ашиглагдаж буй нийт автобусны буудлуудын 400 метр радиусын хүртээмжид хамрагдаж байгаа болон хамрагдахгүй байгаа нэгж талбаруудын тоог гаргасан. Автобусны буудлын хүртээмжид хамрагдахгүй байгаа хэсэгт нэмж барих буудлуудын санааг дэвшүүлсэн.



"Токиогийн Гудамж" судалгааны ажилд хамтран ажиллах

Сайтама, Вакаяма болон Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулиудын хамтран хэрэгжүүлж буй "Токиогийн Гудамж" судалгааны ажилд хамтран ажиллаж, 3-р сарын 4-ны 14:30-16:30 цагийн хооронд Zoom хуралд Улаанбаатар хотын үүсэл хөгжил, түүхийн талаар Г.Хосбаяр танилцуулга хийж, хэлэлцсэн.


Хот байгуулалт, хөгжлийн газрын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний самбарын загварыг боловсруулах.

Хот байгуулалт, хөгжлийн газрын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний самбарын загварыг боловсруулж Захиргаа санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгсөн



"НИЙСЛЭЛ - ХОТ БАЙГУУЛАЛТ" сэдэвт танилцуулга боловсруулах.

Нийслэлийн Засаг даргын Барилга, хот байгуулалт хариуцсан төслүүдийн удирдагч Б.Сүхбаатар даргын Засгийн газрын хуралдаанаар танилцуулах "НИЙСЛЭЛ - ХОТ БАЙГУУЛАЛТ" сэдэвт танилцуулгыг бэлтгэж 05-р сарын 12-ний өдөр танилцуулсан.



"Нийслэлийн нийгмийн хангамжийн дэд бүтцийн хүртээмж" танилцуулга боловсруулах.

Нийслэлийн нийгмийн хангамжийн дэд



бүтцийн хүртээмжийн судалгаа хийж танилцуулгын загварыг боловсруулж танилцуулгыг бэлтгэсэн.

Гандантэгчэнлин хийдийн одоогийн байдал болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний танилцуулга бэлтгэх.

Баянгол дүүргийн 16 дугаар хороонд байрлах Гандантэгчэнлин хийдийг Юнеско-Дэлхийн соёлын өвд бүртгүүлэх талаар цахим хуралдаанд танилцуулах Гандантэгчэнлин хийдийн одоогийн байдал болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний танилцуулга бэлдэн газрын даргад танилцуулсан.

Хот байгуулалт, хөгжлийн газрын 2021 оны үйл ажиллагааны танилцуулга боловсруулах.Хот байгуулалт, хөгжлийн газрын танилцуулга боловсруулах.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр харьяа байгууллагуудын албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, санал солилцох уулзалтын хүрээнд Газрын даргын танилцуулах Хот байгуулалт, хөгжлийн газрын 2021 оны үйл ажиллагааны танилцуулгыг боловсруулсан

Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаа эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд хийгдсэн томоохон ажлын танилцуулга.

Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаа эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд хийгдсэн томоохон ажлууд болон цаг үеийн ажлын мэдээллийг боловсруулж 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Үүнд:

- Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
- Хот байгуулалтын зарим үйл ажиллагааг түр зогсоох тухай
- Орон сууцны VII нэгж хороолол
- Дэд төв, олон нийтийн төв
- Цагийн хязгаартай ажиллах гудамж талбай
- Богдхан уул, туул голын эрэг дагуух тохижилт

Барилгын хувийн хэрэг, зураг төслийн баримтыг төрийн архивын байнгын хадгалалтад шилжүүлэх.

Барилгын хувийн хэрэг, зураг төслийн баримтыг төрийн архивын байнгын хадгалалтад шилжүүлэхтэй холбоотой 37 хайрцаг материалыг архивын газрын шаардлагын дагуу албаны нийт албан хаагчид бэлтгэн Захиргаа санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгсөн.

“Сэлбэ” гол дагуух тохижилтын танилцуулга боловсруулах.

2021 оны 06 дугаар сарын 03-ний өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Сүхбаатар дүүрэгт ажиллахад “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичиг”-т голуудын хэрхэн хөгжүүлэх, “Сэлбэ” гол дагуух тохижилт хийгдсэн танилцуулга 3 самбар эхийг боловсруулсан.

Газрын харилцаа, хот байгуулалтын үйл ажиллагааны нэгдлийг хангах, төлөвлөлт, менежментийн бодлогыг хамтран хэрэгжүүлэх.


Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, “Хот Төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дарга нарын хамтарсан 2021 оны А/25, А/53, А/37 тушаалаар Газрын харилцаа, хот байгуулалтын үйл ажиллагааны нэгдлийг хангах, төлөвлөлт, менежментийн бодлогыг хамтран хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсантай холбогдуулан Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд шаардлагатай байгаа батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээ, төсөл хөтөлбөрийг тоон хэлбэрээр болон зураглалын альбом болгон бэлтгэж 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 02/2034, 02/2036 дугаартай албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2021/01 дугаар акт үйлдэн хүлээлгэн өгсөн.

2021 оны 09 дүгээр сар 22-ний өдөр ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын гүйцэтгэлийг хэлэлцэж бодлогын баримт бичгийн уялдааг хангуулах,

мэдээлэл солилцож ажлын хэсгийн гишүүдээс гарсан санал зөвлөмжийг бодлогын баримт бичгүүдэд тусгуулахаар шийдвэрлэв.

[Богдхан төмөр замын трасс-ын маршрутын судалгаа хийх.](#)

Нийслэлийн засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн шуурхай хуралдаанаар Богдхан төмөр замын нөлөөлөлд өртсөн иргэдийн газрын байршлыг шилжүүлэх асуудлыг судалж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барих үүрэг даалгавар өгсөн. Тус үүрэг даалгаврын дагуу Богдхан төмөр замын шинээр төлөвлөж буй чиглэл /трасс/ хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан давхцалын талаар танилцуулга бэлтгэн ажилласан.



[Сэлбэ гол дагуу хийгдсэн голын эргэ дагуух тохижилтын ажлын зураг төслийн мэдээлэл бэлтгэх.](#)

2021 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Сэлбэ гол дагуу хийгдсэн голын эргийн дагуух тохижилтын ажлын зураг төсөл хийгдсэн мэдээлэл бүхий 4ш самбарын эх загварын өөрчлөлтийг засварлаж бэлтгэн хэвлүүлэн танилцуулсан.

[Шинэ нутгийн захиргааны өрөөний интерьер дизайны зураг боловсруулах.](#)

2021 оны 11 дүгээр сарын 17-ноос 2021 оны 11 дүгээр сарын 19-ны өдрүүдийн хооронд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн орлогч дарга нарын Яармагт байрлах шинэ нутгийн захиргааны ордны өрөөний интерьер дизайны зургийг хийж гүйцэтгэсэн.



[Газрын даргын 2021 оны “Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулах” А/15 дугаар тушаал](#)

Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн А/15 дугаар тушаалаар Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх тэдгээрийн үзэл бодлыг сонсох, санал санаачилгыг дэмжих

замаар залуучуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийг байгуулсан. Тус зөвлөлийн 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж газрын даргаар батлуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Үндэстний үзэл, хэл соёл, уламжлалт хэл бичгээ дээдлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Залуучуудын хөгжлийн Зөвлөлөөс Монгол бичгийн сургалтыг 7 хоног бүрийн 2 өдөрт тогтмол зохион байгуулж байна.
- Сайн үйлсийн аяны хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Цус сэлбэлт, судлалын үндэсний төвтэй хамтран нийт албан хаагчдын дунд “Цусаа хандивлах” үйл ажиллагааг 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.

Монголын Архитекторуудын Эвлэлийн түүхт 65 жилийн ойн баярт зориулсан дүрсгалын загварыг боловсруулсан.



Байгууллагын зүгээс 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын танилцуулга бэлтгэх:

Байгууллагын зүгээс 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын танилцуулгад Хөгжлийн алтан тойрог буюу Дагуул хот, тосгодыг холбосон нийтийн тээврийн сүлжээ байгуулах, Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах, Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийн төсөл боловсруулах ажлын талаар мэдээлэл, нэгжүүдийн танилцуулгыг нэгтгэн боловсруулж ажилласан.

ШИНЭ САНААЧИЛГА БҮТЭЭЛЧ АЖИЛ

- “Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах судалгаа, шийдэл”-ийг боловсруулж 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар болон



Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Зам тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Одсүрэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Т.Оюунчимэг нарт танилцуулсан. Тус судалгааны ажлыг олон нийтийн хүртээл болгох зорилгоор I-UP санаачилгын хүрээнд цахим бичлэг болгон тайлбарлаж байршуулсан.

- Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор багтаамж ихтэй тээврийн хэрэгсэл ONORAIL-ийг төлөвлөх чиглэл өгсний дагуу гадаад орны судалгаа, маршрутын судалгаа, техникийн нөхцөлийн судалгааг боловсруулж 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Хот байгуулалт, хөгжлийн газрын даргад танилцуулсан.



- Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг олон нийтэд таниулах, олон нийтийн хот байгуулалт, төлөвлөлтийн тухай ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд “Хотын хөгжлийг хамтдаа хэлэлцье” уриатай подкастыг ярилцлага, судалгаа мэдээлэл, иргэдийн сурвалжилга хэлбэрээр бэлтгэн “SPACIAL PLANNING PODCAST” цахим хаягаар олон нийтэд хүргэсэн.



- Хотын ирээдүйн эзэд болсон хүүхэд багачуудын мөрөөдлийн хотын төсөөлөл, тэдний үзэл бодлоо чөлөөтэй, бүтээлч байдлаар илэрхийлэхэд урам өгөх зорилгоор “МӨРӨӨДЛИЙН ХОТ” хүүхдийн гар зургийн уралдааныг 6-7, 8-9, 10-12 насны ангиллаар 2021 оны 05 дугаар сарын 5-ны өдрөөс 05 дугаар сарын 18-ний өдөр хүртэл зохион байгуулсан. Уралдаанд Улаанбаатар хот, Эрдэнэт хот, Булган, Хэнтий, Увс аймгуудаас хүүхэд багачууд оролцож ирүүлсэн бүтээлүүдийг 2021 оны 05 дугаар сарын 19-ны өдрөөс 05 дугаар сарын 23-ний өдрийн хооронд spatial planning podcast-ын Facebook page хуудсанд байршуулан олон нийтээс санал авч комиссын бүрэлдэхүүний үнэлгээгээр уралдааны тэргүүн байр, дэд байр, гутгаар байр эзэлсэн авьяаслаг хүүхэд, багачуудад шагнал гардуулж урамшуулсан.



ТАНИЛЦУУЛГА

- Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх танилцуулгыг бэлтгэж НИТХ-ын АН-ын бүлэгт хүргүүлсэн.
- Монголын Архитекторуудын эвлэлийн мэргэшсэн зэрэг горилж байгаа архитекторуудад “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-өөг боловсруулах үйл явц, үзэл баримтлалын талаар танилцуулга хийсэн.
- Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан хотын төв, дэд төв, олон нийтийн төвүүдийн бүтээн байгуулалт, хэрэгжилтийн талаар танилцуулга бэлтгэсэн.
- Нийслэлийн Зам тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагчийн Засгийн газрын хуралдаанд танилцуулах “Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний танилцуулгад тусгуулах саналыг бэлтгэн ажилласан.
- Нийслэлийн хэмжээнд одоо байгаа болон төлөвлөж байгаа сургууль, цэцэрлэгийн хүчин чадлын тооцоо болон байршлыг тодорхойлж нэгдсэн зураг бэлтгэж нийслэлийн засаг даргын орлогч Б.Одсүрэнд танилцуулсан.
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр болсон цахим хуралдаанд танилцуулсан Улаанбаатар хотын 2020 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголын хэрэгжилт, Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн бодлого, хотын 2040 он хүртэлх хөгжлийн үзэл баримтлалын талаарх танилцуулгыг бэлтгэсэн.
- Богдхан уулын урд талаар төмөр замын төлөвлөлт “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-д хэрхэн төлөвлөгдсөн талаарх танилцуулга бэлтгэж Газрын даргад өгсөн.
- Нийслэлийн Засаг дарга Монгол Улсын Засгийн газрын хуралд танилцуулах Нийслэл Улаанбаатар хотод тулгамдсан асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаарх танилцуулгыг бэлтгэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.
- Монгол улсын Засгийн газраас тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээнд тусгуулах Нэг төвт хотоос олон төвт хот болгох зорилтын хүрээнд Улаанбаатар хотод шинээр 3 дэд төв, 7 олон нийтийн төв байгуулах ажлын судалгаа, хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоо, хэрэгжүүлэх ажлын үе шатны танилцуулга болон төслийн үндсэн мэдээллийн хүснэгтийг загварын дагуу боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтэст хүргүүлсэн. Мөн 3 дэд төв, 7 олон нийтийн төв байгуулах асуудлыг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлтөд тусгуулах саналыг хүргүүлсэн.

- Нийслэлийн Засаг даргын Барилга, хот байгуулалт хариуцсан төслүүдийн удирдагч Б.Сүхбаатар даргын Засгийн газрын хуралдаанаар танилцуулах “НИЙСЛЭЛ-ХОТ БАЙГУУЛАЛТ” сэдэвт танилцуулгыг бэлтгэж Б.Сүхбаатар даргад хүлээлгэн өгсөн.
- Чингэлтэй дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Гутлын 22 гудамжийг ойр орчимд нь ажилладаг төрийн албан хаагчид болон оффисын ажилчдад зориулсан “Өглөөний гудамж” төслийн талаарх танилцуулгыг бэлтгэн ажилласан.
- Баянгол дүүргийн 16 дугаар хороонд байрлах Гандантэгчэнлин хийдийг Юнеско-Дэлхийн соёлын өвд бүртгүүлэх талаар цахим хуралдаанд танилцуулах Гандантэгчэнлин хийдийн одоогийн байдал болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний танилцуулга бэлтгэн газрын даргад танилцуулсан.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар 2021 оны 05-р сарын 24-ний өдөр харьяа байгууллагуудын албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, санал солилцох уулзалтын хүрээнд Газрын даргын танилцуулах Хот байгуулалт, хөгжлийн газрын 2021 оны үйл ажиллагааны танилцуулгыг бэлтгэн газрын даргад хүлээлгэн өгч ажилласан.
- Хот байгуулалтын Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг батлагдах хууль эрхзүйн үндэслэл, зөвшөөрөл авах үе шатууд, бүрдүүлэх материалын талаар танилцуулга боловсруулан Отгонсүх даргад танилцуулсан.
- Улаанбаатар хотыг дагуул хот, тосгодтой холбох Богдхан уулыг тойрсон “Хөгжлийн алтан тойрог” буюу нийтийн тээврийн сүлжээг байгуулах танилцуулгыг бэлтгэн Нийслэлийн Хот байгуулалтын асуудал хариуцсан төслүүдийн удирдагчид хүргүүлсэн.
- 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Богдхан төмөр замын ажлыг Монгол улсын Засгийн газарт танилцуулах болсонтой холбоотойгоор 30 хуудас бүхий хэвлэмэл танилцуулгыг 5 хувь бэлтгэн Газрын даргад өгсөн.
- Байгууллагын зүгээс 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын танилцуулгад Хөгжлийн алтан тойрог буюу Дагуул хот, тосгодыг холбосон нийтийн тээврийн сүлжээ байгуулах, Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах, Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийн төсөл боловсруулах ажлын талаар мэдээлэл, танилцуулга бэлтгэж ажилласан.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

А.БАТТӨМӨР

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН
АЖЛЫН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН

Б.ӨЛЗИЙЖАРГАЛ